



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР



100
ХОНОГ

АЖЛЫН ТАЙЛАН
2021.01.29–2021.05.09

1

ЦАР ТАХЛЫГ БОГИНО ХУГАЦААНД ДАВАН ТУУЛАХ ЗОРИЛТ



2

ЭДИЙН ЗАСГАА СЭРГЭЭХ ЗОРИЛТ



3

АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ ДЭЭШЛҮҮЛЖ, ДУНДАЖ ДАВХАРГЫГ ДЭМЖИХ ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦООГ БИЙ БОЛГОХ ЗОРИЛТ



4




ШУДАРГА ЁС, ЦАХИМ ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭХ ЗОРИЛТ







**ЦАР ТАХЛЫГ
БОГИНО ХУГАЦААНД
ДАВАН ТУУЛАХ ЗОРИЛТ**



ЦАР ТАХЛЫГ БОГИНО
ХУГАЦААНД ДАВАН ТУУЛАХ
ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД



ВАКЦИН ТАТАН АВАЛТ


ХҮН АМАА ВАКЦИНЖУУЛАХ АЖЛЫГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАВ

Ковид-19-ийн халдвараас сэргийлэх, тархалтыг бууруулах, хүндрэл, эндэгдлээс сэргийлэх чухал ач холбогдолтой хүн амаа вакцинжуулах ажлыг Засгийн газар 2021 оны 2 дугаар сарын 22-ны өдрөөс эхлүүлээ. Монгол Улсын Засгийн газраас 5 төрлийн вакциныг 2021 оны 2 дугаар сарын 22-ны өдрөөс 5 дугаар сарын 6-ны өдрийг хүртэл нийт 13 удаагийн татан авалтаар **2,924,940** хүн/тунг татан авч, хүн амыг вакцинжуулж байна.

Ковакс хөтөлбөрийн хүрээнд АстраЗенека, Файзер вакцины нийт 90,540 хүн/тунг хүлээн авсан бөгөөд дараагийн ээлжийн 148,620 хүн/тун вакциныг ирэх 6 дугаар сард хүлээн авна.

Монгол улсад Энэтхэг улсаас 150,000 хүн/тун Астразенека вакцин, БНХАУ-аас 300,000 хүн/тун Вероселл вакциныг хүмүүнлэгийн шугамаар хандивлалаа. Монгол Улсын Засгийн газар иргэдээ вакцинд бүрэн хамруулахын тулд ОХУ-аас 1,000,000 хүн/тун Спутник-В вакциныг худалдан авах гэрээ байгуулсан бөгөөд тус вакцины эхний ээлжийн 50,000 хүн/тун вакциныг нийлүүлээд байна.

Мөн БНХАУ-аас 2,634,400 хүн/тун Вероселл вакциныг худалдан авах гэрээг байгуулж, 2,334,400 хүн/тунг татан аваад байна.



Ковид 19–ийн вакцинжуулалтыг эхлэхээс өмнө бэлтгэл ажлын хүрээнд 21 аймаг, 9 дүүргийн 4,553 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, бусад салбарын мэргэжилтнүүдийг хамруулсан 18 удаагийн цахим сургалтыг зохион байгуулж, бэлтгэл ажлыг хангалаа. Ковид–19–ийн вакцинжуулалтад хамрагдаж буй иргэдийг системд бүртгэлжүүлж байна.



ДАРХЛААЖУУЛАЛТЫН ЭМЧ, СУВИЛАГЧ

Вакцины төлөвлөлт, захиалга, эмчийн үзлэг, тарилгын мэдээллийг www.health.gov.mn дархлаажуулалтын цахим системд бүртгэнэ.



ВАКЦИНД ХАМРАГДСАН ИРГЭН

www.e-mongolia.mn төрийн үйлчилгээний нэгдсэн порталаас Вакцины сертификатыг авч, цаашид вакцины дараа илэрч буй урвалыг бүртгүүлнэ. Мөн vis.health.gov.mn/survey тандалтын программд дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийн мэдээллийг бүртгүүлнэ.



ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА


vis.health.gov.mn/ тандалтын программаас тайланг авч нэгтгэж дүн шинжилгээ хийх ажлыг зохион байгуулж байна.

Монгол Улсын Засгийн газар Ковид–19–ийн вакцинд нийт хүн амын насанд хүрсэн 60 хувь болох 2,067,292 иргэнийг хамруулах зорилттой ажиллаж байна. Тус зорилтын хүрээнд 2021 оны 5 дугаар сарын 8–ны өдрийн байдлаар Улаанбаатар хотод нийт 101 суурин, 20 явуулын цэгт 262 багийн 2,500, хөдөө орон нутагт 10,000 эрүүл мэндийн ажилтан ажиллаж байна.

ЦАР ТАХЛЫГ БОГИНО ХУГАЦААНД ДАВАН ТУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

“ 2021 оны 5 дугаар сарын 10–ны өдрийн байдлаар зорилтот бүлгийн 77.2 хувь буюу 1,595,949 иргэнийг эхний тунгаар, зорилтот бүлгийн 30.2 хувь буюу 624,322 иргэнийг хоёр дахь тунгаар вакцинжуулаад байна. ”

ВАКЦИНЖУУЛАЛТЫН ЯВЦ





ГАДААДААС ЯАРАЛТАЙ ИРЭХ ХҮСЭЛТ ГАРГАСАН ИРГЭДЭЭ ТАТАН АВЛАА

ЦАР ТАХЛЫГ БОГИНО
ХУГАЦААНД ДАВАН ТУУЛАХ
ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

2021 оны 1 дүгээр сарын эцсийн байдлаар 9,143 иргэн нутаг буцах хүсэлтээ гаргасан байсан бөгөөд үүнээс яаралтай ирэх хүсэлт гаргаад байсан 2,692 иргэнийг бүрэн татан авч дуусгав.


2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдрөөс 4 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл тусгай үүргийн 43 нислэгээр 5,216, Монгол-Хятадын боомтоор 71, Монгол-Оросын боомтоор 71, нийт 5,358 иргэнээ эх оронд ирүүлэх ажлыг зохион байгууллаа.



Коронавируст халдвар (Ковид-19) –аас урьдчилан сэргийлэх вакцинд хамрагдаж, 14 ба түүнээс дээш хоногийн хугацаа өнгөрсөн бол тусгаарлах байранд тусгаарлахгүй.



Тусгаарлах хугацаанд 6 дахь хоногт 1 удаа PCR шинжилгээ авч сөрөг гарсан иргэнийг гэрийн ажиглалтад 7 хоног тусгаарлана.



Гадаадаас ирэх эцэг, эх нь вакцинд хамрагдаад 14 хоногоос дээш хугацаа өнгөрсөн ч бага насны хүүхэдтэй ирвэл 7 хоног тусгаарлах байранд тусгаарлана.

ТАТАН АВСАН

Нийт 5,358 ИРГЭН	5,216 ИРГЭН	142 ИРГЭН
		



ЦАР ТАХЛЫГ ДАВАН ТУУЛАХАД ЗАСГИЙН ГАЗАР ИРГЭН БҮРТЭЙГЭЭ ХАМТ

Цар тахалтай тэмцэж буй хүнд хэцүү цаг үед иргэдийн амьжиргааг дэмжих зорилгоор хүүхдийн мөнгийг 100 мянган төгрөг хүртэл нэмэгдүүлж, ус, цахилгааны хэрэглээний төлбөрийг төрөөс төлж, иргэдийн бизнесийн болон хэрэглээний, ипотекийн зээлийн эргэн төлөлтийг хоёр ч удаа хойшлуулсан билээ.

Мөн Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах зорилгоор бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж байгаатай холбогдуулан хөл хорионы улмаас иргэдийн санхүү, орлогын тасалдал үүсэх эрсдэлтэй учир 3.3 сая иргэн бүрд хөл хорионы үеэр 300 мянган төгрөгийн дэмжлэгийг нэг удаа олголоо.

Иргэн бүрд олгох үйл ажиллагааг Үндэсний статистикийн хорооноос гаргасан хүн амын тоонд үндэслэн Монгол Улсын 3,375,025 иргэнд 1 их наяд 12 тэрбум төгрөгийг олгож байна.

Мөн вакциныхаа 2 тунг хийлгэсэн иргэдийн эрүүл мэндийг дэмжих зорилгоор 50 мянган төгрөгийг олгож байна.

МОНГОЛ УЛСЫН ИРГЭН БҮРД

300,000 ₮

АНХ УДАА МОНГОЛ УЛС **1.12** ИХ НАЯД
ТӨГРӨГИЙН ДЭМЖЛЭГИЙГ ОЛГОЖ
БАЙНА.

ЦАР ТАХЛЫГ БОГИНО
ХУГАЦААНД ДАВАН ТУУЛАХ
ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

“

Анх удаа Монгол Улсын иргэн бүрд ийнхүү мөнгөн дэмжлэгийг олгож буйгаараа онцлог бөгөөд цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх хөл хорионы үед иргэдэд санхүүгийн бодит дэмжлэг боллоо.

”



ЦАР ТАХЛЫН ҮЕИЙН ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЛБАРЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

ЦАР ТАХЛЫГ БОГИНО
ХУГАЦААНД ДАВАН ТУУЛАХ
ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

**ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ
КОМПАНИУДЫН
ДЭМЖЛЭГ**

01

**ИРГЭДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙГ
БҮРТГЭХ СИСТЕМ**



Аж ахуйн нэгж байгууллагууд www.qr.119.mn цахим хуудсаар өөрийн QR кодыг үүсгэх, Иргэд И-баримт аппликейшныг ашиглан QR кодыг уншуулах зарчмаар систем ажилладаг.

02


**АЖИГЛАЛТАД ШИЛЖИЖ
БАЙГАА ИРГЭДИЙГ БҮРТГЭХ**



Тусгаарлах байрнаас гарч гэрийн ажиглалтад шилжиж байгаа иргэдийг бүртгэх, шилжилт хөдөлгөөнийг хянах зорилготой "GPS CLIX" систем юм.

03

**"ЭРҮҮЛ.МН" ТӨСЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНД МАБ-Н
ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ**



"Гэрэгэ Системс" ХХК-ний хэрэгжүүлж байгаа "ЭрүүлМН" төслийн үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийв.

04

**ИРГЭДЭД МЭДЭЭЛЭЛ
ХҮРГЭХ ТУСГАЙ ДУГААР**



Операторын тоог хувийн хэвшлээр хүч нэмэгдүүлсэн. Холбох шугамын багтаамжийг ихэсгэв.

1.2 ТЭРБУМ
төгрөгийн хандив өгөв
ХАНДИВ

18 ТЭРБУМ
847 сая SMS үнэгүй илгээв
СЭРЭМЖЛҮҮЛЭГ МЭССЭХ

05

**EXPOSURE NOTIFICATION
(ENX) СИСТЕМ**




Apple, Google, Оном сан, Гэрэгэ Системс ХХК-тэй хамтарч хэрэгжүүлсэн

315,568
хэрэглэгч ашиглаж байна
2021/04/27

06

**УОК ШУУРХАЙ ШТАБЫН
НЭГДСЭН ХЯНАЛТЫН
САМБАР**



Нэгдсэн хяналтын самбар нь Ковид 19 цар тахлын үед УОК-д ирж буй мэдээ, мэдээллийг нэгтгэх, удирдлагыг үнэн зөв мэдээллээр түргэн шуурхай хангах, мэдээллийн давхардал, зөрүүг арилгахад чиглэсэн.

07

**ОЛОН УЛСЫН ВАКЦИНЫ
ГЭРЧИЛГЭЭ**



Эрүүл мэндийн кодыг харилцан хүлээн зөвшөөрч солилцох техникийн шийдэл боловсруулж, дүгнэлт зөвлөмж гаргах ажлыг гүйцэтгэж байна.

08

**ХАТУУ ХӨЛ ХОРИОНЫ
ТЕХНИКИЙН БЭЛЭН БАЙДАЛ
ХАНГАХ**



QR@GOV.MN имэйлийг нээж, хэвийн найдвартай ажиллагааг хангав. 14560 ширхэг 45 гигабайт имэйл ирсэн. smartcar.mn системийн виртуал серверийн үзүүлэлтийг 3 дахин нэмэгдүүлсэн.

271 ТЭРБУМ
үнэгүй дата
ЦАХИМ ХИЧЭЭЛ

КОРОНАВИРУСТ ХАЛДВАРЫГ ИЛРҮҮЛЭХ ЛАБОРАТОРИ БАЙГУУЛЛАА

Өвөрхангай аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Архангай Баян-Өлгий, Увс, Хөвсгөл, Хэнтий, Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлэг, Улаанбаатар хотын УХТЭ, Багануур дүүрэг болон Налайх дүүргийн нэгдсэн эмнэлэгт ПГУ хийх молекул биологийн лабораториудыг байгууллаа.

10 байршилд ПГУ-ын шинжилгээ хийж байсан бол одоо 33 байршилд 45 ПГУ-ын аппарат ашиглан үйл ажиллагаа явуулж байна. Хоногтоо нийт 15,000 сорьцод Ковид-19 илрүүлэх шинжилгээг хийх хүчин чадал бүрэн бүрдэж, эрүүл мэндийн байгууллагуудын чадавх сайжирлаа.



ЦАР ТАХЛЫГ БОГИНО
ХУГАЦААНД ДАВАН ТУУЛАХ
ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

“ ПГУ-ын молекул биологийн лабораторийг байгуулснаар хөдөө орон нутгаас халдвар илрүүлэх зорилгоор Улаанбаатар хот руу сорьц тээвэрлэх зардлыг бууруулж, шинжилгээний хариуны хүлээгдлийг багасгаж, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын чадавхыг сайжруулаад байна. ”







ЭДИЙН ЗАСГАА СЭРГЭЭХ ЗОРИЛТ





ЭРҮҮЛ МЭНДЭЭ ХАМГААЛЖ, ЭДИЙН ЗАСГАА СЭРГЭЭХ 10 ИХ НАЯДЫН ЦОГЦ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЖ ЭХЛЭВ

ЭДИЙН ЗАСГАА СЭРГЭЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө боловсруулан иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийг дэмжин ажлын байрыг хадгалах, амьжиргааг дэмжих, эдийн засгийн хүндрэлээс сэргийлж, эрчимжүүлэх чиглэлээр боломжит бүхий л нөөц бололцоогоо дайчлан ажиллаж байна.

НИЙТ ОЛГОЛТ:

1,326.4
тэрбум ₮

НИЙТ ГҮЙЦЭТГЭЛ:

13.3%

2021 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ:

21.9%



АЖЛЫН БАЙРЫГ ДЭМЖИХ ЗЭЭЛ



ХОЁР ИХ НАЯДЫН ДАХИН САНХҮҮЖҮҮЛЭХ (РЕПО) ТӨЛӨВЛӨГӨӨ




ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ЗЭЭЛ




Төлөвлөгөөний хүрээнд эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг цар тахлын өмнөх түвшинд буюу эдийн засгийн өсөлтийг 5.2 хувиас багагүй түвшинд хүргэн сэргээж, ажлын байрыг дэмжихийн зэрэгцээ инфляци, гадаад валютын албан нөөцийг мөнгөний бодлогын зорилтот түвшинд барих зорилт тавьж байна. Түүнчлэн, ажлын байрыг дэмжих зээлийн хүрээнд нийт 3,500 аж ахуйн нэгж, 20,000 иргэнд зээл олгож 120,000 мянган ажлын байрыг дэмжихээр тооцсон. Түүнчлэн, эрүүл мэндээ хамгаалах төлөвлөгөөний хүрээнд нийт хүн амын 60 хувь буюу 2.0 сая гаруй иргэдийг вакцинжуулалтад хамруулах зорилт тавьж хэрэгжүүлж байна.

АЖЛЫН БАЙРЫГ ДЭМЖИХ ЗЭЭЛ



РЕПО САНХҮҮЖИЛТИЙН ЗЭЭЛ



ТОМ ТӨСЛҮҮДИЙН САНХҮҮЖИЛТ	ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗЭЭЛ	ЗАЛУУСЫГ ХӨДӨЛМӨРТ БЭЛТГЭХ СУРГАЛТ	ОРОН СУУЦНЫ ХОРООЛЛЫН ДЭД БҮТЭЦ
Төлөвлөгөө: 2,000.0 тэрбум ₮	Төлөвлөгөө: 500.0 тэрбум ₮	Төлөвлөгөө: 500.0 тэрбум ₮	Төлөвлөгөө: 1,000.0 тэрбум ₮
Гүйцэтгэл (%): 22.2%	Гүйцэтгэл (%): 0%	Гүйцэтгэл (%): 0%	Гүйцэтгэл (%): 0%

2021.05.10–ны өдрийн байдлаар

Уг төлөвлөөг хэрэгжүүлснээр 2021 оны гүйцэтгэлээр эдийн засгаа тогтворжуулж, макро үзүүлэлтүүдийг 2019 оны эцэс буюу цар тахлын өмнөх түвшинд хүргэх зорилго тавин ажиллаж байна. “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хэрэгжилтэд хяналт тавьж, эрчимжүүлэх үүднээс долоо хоног бүр Засгийн газрын хуралдаанд танилцуулж, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлж байна. Ажлын байрыг дэмжих болон Монголбанкны Репо санхүүжилтийн хүрээнд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч буюу ажил олгогч иргэн, аж ахуйн нэгжийн нийт 120 мянган ажлын байрыг хадгалахаар зорьж байгаа бөгөөд одоогоор зээл авсан иргэн, аж ахуйн нэгжийн 40.7 мянган ажлын байрыг хадгалж чадсан байна.

ЭДИЙН ЗАСГАА СЭРГЭЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

“*Эрсдэлтэй байсан 43,882 ажлын байрыг хадгалж үлдэв.*”





КОВИДЫН ДАРААХ ЭДИЙН ЗАСГИЙГ СЭРГЭЭХ 100 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТОДОРХОЙЛЛОО

ЭДИЙН ЗАСГАА СЭРГЭЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД



Төлбөрийн тэнцэл, эдийн засгийн өрсөлдөх чадвар сайжирч, ажлын байр, иргэдийн орлого өсөж, нийгмийн дундаж давхарга нэмэгдэж, бизнесүүдийн бүтээмж, инновацийн түвшин дээшилж, төрийн үйлчилгээ ил тод, тэгш, хүртээмжтэй болно.



Экспортыг нэмэгдүүлж эдийн засгийг хурдтай томруулах, цаашид үсрэнгүй хөгжлийн суурийг бэхжүүлэх 100 төсөл, арга хэмжээг тодорхойлон хөрөнгө оруулагчдад санал болгож байна.

Ковид-19-ийн цар тахлын дараагаар агшсан эдийн засгаа богино хугацаанд сэргээх, цаашид экспортыг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн цар хүрээгээ эрчимтэй тэлэх, төрөлжүүлэх зорилгоор тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг, хувийн хэвшил болон гадаадын хөрөнгө оруулагчидтай хамтран хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангалаа. Засгийн газрын гишүүд болон Экспортыг нэмэгдүүлж, төлбөрийн тэнцлийн дарамтыг бууруулах ач холбогдол, бодлогын баримт бичигт нийцсэн байдал, эдийн засгийн тэргүүлэх чиглэлд багтсан байдал зэргийг харгалзан эдгээр төсөл, арга хэмжээг эрэмбэлээд байна. Эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэсэн 50 төсөл, амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн 30 төсөл, эдийн засгийн суурь бүтцийн өөрчлөлтөд шаардлагатай бодлогын шинэчлэлийн 20 арга хэмжээг багтаасан болно.

Төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжсэнээр төлбөрийн тэнцлийн дарамт буурч, гадаад өрийг бууруулах, ам.доллараар илэрхийлсэн эдийн засгийн хэмжээ тэлэх боломж бүрдэнэ. Мөн өнөөдрийн түвшинтэй харьцуулахад 210 мянга орчим ажлын байр нэмэгдэхээс гадна дотоодын үйлдвэрлэл нэмэгдсэнээр 1.5 тэрбум ам.долларын импортыг орлож, экспортын орлого 6.1 тэрбум ам.доллараар нэмэгдэнэ. Нэг хүнд ногдох ДНБ 2030 онд 10 мянган ам.долларт хүрч, иргэдийн амьдралын чанар сайжирна. Эдийн засгийн бүтэц үйлчилгээ, хөдөө аж ахуйн салбараас аж үйлдвэрийн салбар руу шилжиж, Монгол Улсын тогтвортой хөгжлийн суурийг бэхжүүлэх юм.



+210,000

ажлын байр

1,5\$ тэрбум — импорт
экспорт ← 6,1\$ тэрбум

хүнд ногдох ДНБ

2020 он 4,167\$ → 2030 он 10,000\$

100

төсөл арга хэмжээ

20

Бодлогын шинэчлэлийн арга хэмжээ

50

Эдийн засгийн төсөл

30

Амьдралын чанарыг дээшлүүлэх төсөл

ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД, ДОТООД ӨРИЙГ ХУГАЦААНД НЬ ТӨЛЖ БАРАГДУУЛАВ


Засгийн газрын гадаад, дотоод өр төлбөрийг хугацаанд нь төлж барагдуулан хөрөнгө оруулагчид, зээлдүүлэгчдийн өмнө хүлээсэн үүргээ хариуцлагатай биелүүлж байна.

Засгийн газрын зүгээс Улсын Их Хурлын 2019 оны 55 дугаар тогтоолоор батлагдсан “Засгийн газрын өрийн удирдлагын 2019–2022 оны стратегийн баримт бичиг”-т тусгагдсан дунд хугацааны зорилтуудын хүрээнд гадаад, дотоод зээллэгийн төлбөрийг төсөв, эдийн засагт дарамт учруулахгүйгээр төлж дахин санхүүжилтийн эрсдэлийг багасгах, арилжааны нөхцөлтэй гадаад зээллэг болон болзошгүй өр төлбөрийн хэмжээг бууруулах, улмаар улсын зээлжих зэрэглэлийг сайжруулж, хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх бодлогыг баримтлан ажиллаж байна.


Засгийн газрын зүгээс Засгийн газрын өрийн үйлчилгээний төлбөрт 2021 оны 1–4 дүгээр сард нийт 1,005.8 тэрбум төгрөг, үүнээс үндсэн төлбөрт 765.4 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 240.4 тэрбум төгрөгийг төлж барагдууллаа.



ЭДИЙН ЗАСГАА СЭРГЭЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД



Засгийн газрын өрийн үйлчилгээний төлбөр (тэрбум ₮)



Гадаад зээлийн төлбөрт 424.8 тэрбум төгрөг, гадаад үнэт цаасны төлбөрт 517.1 тэрбум төгрөг, дотоод үнэт цаасны төлбөрт 64.0 тэрбум төгрөгийг тус тус төлсөн.

- 1) Засгийн газрын 2016 оны 3 дугаар сард авсан “Кредит Свисс” банкны 6.5+LIBOR 6 сар хувьсах хүүтэй 250.0 сая ам.долларын арилжааны нөхцөлтэй зээлийн үлдэгдэл 60.0 сая ам.долларын үндсэн төлбөрийг хүүгийн төлбөрийн хамт нийт 61.9 сая ам.доллар буюу 176.4 тэрбум төгрөгийг бүрэн төлж зээлийг дуусгасан;
- 2) 2016 оны 4 дүгээр сард арилжаалсан 10.875 хувийн хүүтэй 500.0 сая ам.долларын Мазаалай бондын үлдэгдэл болох 132.6 сая ам.долларын үндсэн төлбөрийг хүүгийн төлбөрийн хамт нийт 139.9 сая ам.доллар буюу 398.3 тэрбум төгрөгийг төлж барагдуулсан. Эдгээр зээлүүд нь Засгийн газрын гадаад өрийн хамгийн өндөр хүүтэй гадаад зээлүүд бөгөөд тус зээлүүдийг бүрэн төлж барагдуулснаар Засгийн газрын өрийн хүүгийн зардлын төсөвт үзүүлэх нөлөөллийг бууруулахад чухал ач холбогдолтой юм.



Хөрөнгө оруулагчдын Монгол Улсад итгэх итгэлийг нэмэгдүүлж, Монгол Улсын эдийн засаг, төлбөрийн тэнцлийн талаарх эерэг хүлээлтийг үүсгэн, цаашид зээлжих зэрэглэлийг нэмэгдүүлэх, гадаад санхүүжилтийн өртгийг бууруулах зэрэг эерэг нөлөөллийг үзүүлэхээр байна.





ДОТООДЫН ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД “ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК БОНД ГАРГАЛАА

ЭДИЙН ЗАСГАА СЭРГЭЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД



Тавантолгой–Зүүн баян чиглэлийн төмөр зам, Тавантолгой–Гашуун сухайт чиглэлийн төмөр зам, нүүрс баяжуулах үйлдвэр, Тавантолгойн дулааны цахилгаан станцын бүтээн байгуулалтын ажлыг хэрэгжүүлэх санхүүжилтийн эхний хэсгийг амжилттай бүрдүүллээ.





Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөөний хүрээнд стратегийн ач холбогдолтой төслүүдийг санхүүжүүлэх зорилгоор Монгол Улсад анх удаа нийт 2 их наяд хүртэлх төгрөгийн дүн бүхий төгрөг, валют хосолсон “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ЭТТ бондыг гаргаж, эхний арилжаагаар 677 тэрбум төгрөгийг татан төвлөрүүллээ.

“Эрдэнэс Тавантолгой” ХК нь олон нийтэд нээлттэй хэлбэрээр 24–36 сарын хугацаатай, нэг бүр нь 100,000 төгрөг болон 100 ам долларын нэрлэсэн үнэтэй, 2 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий бондыг бүртгэсэн. 2021 оны 3 дугаар сарын 30–ны өдөр арилжааг нээж, 2021 оны 4 дүгээр сарын 9–ний өдрийн 17:00 цагт захиалга хүлээж авах хугацааг тасалбар болгосон юм. Уг бондын арилжаа, санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд нийт 677.7 тэрбум төгрөгийн захиалгыг оролцогч талуудаас ирүүлж, төлөвлөгөөт зорилтыг бүрэн хангасан байна. Үнэт цаасны арилжаанд нийт 973 иргэн, аж ахуйн нэгж оролцож, 2,755,639 ширхэг захиалга ирүүлснээр 347.7 тэрбум төгрөг, банкуудын дахин санхүүжилтийн гэрээний дагуу 330 тэрбум төгрөг буюу нийт 677.7 тэрбум төгрөгийн багцын санхүүжилтийг бүрдүүллээ.



ТАВАН ТОЛГОЙН ЦАХИЛГААН СТАНЦ 

ТӨМӨР ЗАМЫН ТӨСЛҮҮД 


НҮҮРС БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР 

МОНГОЛ УЛСЫН ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛИЙН ТӨЛӨВИЙГ САЙЖРУУЛЛАА

Засгийн газар гадаад, дотоод өр төлбөрийг хугацаанд нь төлж барагдуулан хөрөнгө оруулагчид, зээлдүүлэгчдийн өмнө хүлээсэн үүргээ хариуцлагатай биелүүлж байна.

Зээлжих зэрэглэл тогтоогч “Мүүдиз” агентлаг 2021 оны 3 дугаар сарын 16-ны өдөр Монгол Улсын зээлжих зэрэглэлийг “B3” хэвээр хадгалж, төлөвийг “тогтвортой” болгож ахиуллаа. КОВИД-19 цар тахлын сөрөг нөлөөллөөр буураад байсан Монгол Улсын эдийн засаг тогтворжиж, уул уурхайн экспорт ялангуяа нүүрс, алт, зэсийн экспорт 2020 оны 2 дугаар хагаст сэргэж, гадаад валютын нөөц сайжирсан төдийгүй Засгийн газраас цар тахлын эдийн засагт үзүүлэх нөлөөллийг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн, өрийн дахин санхүүжилтийн арга хэмжээг амжилттай хийсэн зэрэг үйл явц нь зээлжих зэрэглэлийн төлөвийг “тогтвортой” болгоход гол нөлөө үзүүлсэн байна.

AAA AA A BBB BB B CCC/CC SD/D



ЭДИЙН ЗАСГАА СЭРГЭЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

//

Монгол Улсын зээлжих зэрэглэлийг ахиулснаар хөрөнгө оруулагчдын Монгол Улсад итгэлийг нэмэгдүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг өртөг багатайгаар татах боломжийг нэмэгдүүлж байдаг. Нөгөөтэйгүүр зээлжих зэрэглэл тогтвортой байх нь улсын эдийн засгийн хөгжил, төсөв, санхүүгийн чадамж болон Засгийн газрын хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа тогтвортой байгааг илтгэх чухал үзүүлэлтийн нэг юм.

//



ОЮУТОЛГОЙГООС ХҮРТЭХ МОНГОЛЫН ТАЛЫН ҮР АШГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ХЭЛЭЛЦЭЭР ХИЙГДЭЖ БАЙНА

ЭДИЙН ЗАСГАА СЭРГЭЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

Монгол Улсын Засгийн газар байгуулагдаад 100 хоногийн хугацаанд төсвийн орлогыг нэмэгдүүлэх, бизнес, хөрөнгө оруулалтын орчныг дэмжих, гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, татварын тэгш шударга, ил тод байдлыг хангахад чиглэсэн бодлогуудыг хэрэгжүүлж байна.

“Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай” Улсын Их Хурлын 2019 оны 92 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 45 дугаар захирамжаар Ажлын хэсэг байгуулагдаж, Оюутолгойн гэрээхэлцлийг шинэчлэх, хэрэгжилтийг сайжруулах, “Далд уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилтийн төлөвлөгөө” –г хүчингүйд тооцох чиглэлээр хөрөнгө оруулагч тал болох Рио тинтотой хэлэлцээр хийж байна. Тус Ажлын хэсэг татварын олон улсын арбитрын маргаанд Монголын талын эрх ашгийг хамгаалж сөрөг нэхэмжлэл гаргалаа.




Татварын ерөнхий газраас 2018, 2020 онд “Оюу толгой” ХХК-д хийсэн хяналт шалгалтын хүрээнд тавьсан татварын акт болох 1 их наяд төгрөгийн татварын өрийг тус компаниар төлүүлэв.



АРЬС ШИРНИЙ ЦОГЦОЛБОРУУДЫН АЖИЛ ЭРЧИМТЭЙ ЯВАГДАЖ БАЙНА

Дархан арьс, ширний цогцолборт 13 арьс, шир боловсруулах үйлдвэр, 2 ноос, ноолуур угаах самнах үйлдвэр, 2 эсгий хийх үйлдвэр, 1 үйлдвэрлэлийн бохир ус цэвэрлэх байгууламж, 1 судалгаа хөгжил, технологи, инновацийн төв, 1 үйлдвэрээс гарах хаягдлыг боловсруулж желатин үйлдвэрлэх үйлдвэрийг барьж, ашиглалтад оруулна.



Ховд аймгийн Жаргалант суманд арьс, ноос, ноолуур, хаягдал яс, өлөн гэдэс боловсруулах хүчин чадалтай 16–18 үйлдвэр бүхий “Шинэ Ховд үйлдвэр технологийн парк”-ийн барилга угсралтын ажлыг эхлүүлээ.

Тус паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын хүрээнд малын гаралтай түүхий эдийн цэвэрлэх байгууламжийг улсын төсвийн хөрөнгөөр байгуулах ажлыг эхлүүлсэн бөгөөд барилга угсралтын ажлын гүйцэтгэл 80 хувьтай байна.

- ЭСГИЙ ХИЙХ
- ЖЕЛАТИН

ЭДИЙН ЗАСГАА СЭРГЭЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

- АРЬС ШИР → **11 САЯ** Ш
- НООС → **13,000** ТН
- НООЛУУР УГААХ, САМНАХ → **3,300** ТН
- ХАЯГДАЛ ЯС → **3,400** ТН
- ГОГЦОО ӨЛӨН → **440,000** ТН ГЭДЭС

ДАРХАН АРЬС ШИРНИЙ ЦОГЦОЛБОР



Талбай: 180 Га

ШИНЭ ХОВД ҮЙЛДВЭР ТЕХНОЛОГИЙН ПАРК





МАЛЧДАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ

ЭДИЙН ЗАСГАА СЭРГЭЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД



Баянхонгор, Өвөрхангай,
Дундговь, Говь-Алтай,
Өмнөговь аймгийн мал аж
ахуйн салбарын өвөлжилт,
хаваржилтын зудын гамшгийн
эрсдэлийг 30–50 хүртэл хувиар
буурууллаа. Онцгой нөхцөл
байдал, гамшгийн үед шуурхай,
үр дүнтэй хариу арга хэмжээ
авч хэрэгжүүлэх нөхцөлийг
бүрдүүлж, мал сүргийн эрүүл
мэндийг хамгаалах, мал
төллөлт, төл бойжилт болон
нэмүү өртгийн сүлжээний эдийн
засгийн эргэлтийг нэмэгдүүлэх
ээрэг нөлөө үзүүлэв.




Дэлхийн банк, Олон улсын хөгжлийн ассоциацийн 30.0 сая ам. долларын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх” төсөл нь хэрэгжиж байна.

Мал сүргийн эрүүл мэндийг хамгаалах, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээг байгуулах, эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх, гамшгийн үед шуурхай, үр дүнтэй хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх үндсэн зорилготой.

Монгол Улсын Засгийн газар өвөлжилтийн байдал хүндэрч байгаатай холбогдуулан 5.0 сая ам.доллартай тэнцэх хэмжээний хөрөнгийг гаргаж, зудын эрсдэл бүхий Баянхонгор, Өвөрхангай, Дундговь аймгуудын бүх сумд, Говь-Алтай, Өмнөговь аймгийн 74 сумын 45,570 малчин өрхөд хүчит тэжээлийн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулаад байна.

“Мал аж ахуйн салбарын эрсдэлийг бууруулахад авах зарим арга хэмжээ”-ний тухай Засгийн газрын 2021 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаанаар хэлэлцсэн. Үүний үр дүнд нэг малчин өрхөд 100 мянган төгрөгийг, 181.1 мянган малчин өрхөд олгоно. Мөн төслийн хүрээнд баруун болон төвийн бүсэд малын тэжээлийн үйлдвэр байгуулах арга хэмжээг санхүүжүүлэхээр шийдвэрлэв.




45,570

МАЛЧИН ӨРХ

5 САЯ \$

ХҮЧИТ ТЭЖЭЭЛ



ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРТ 100 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛНЭ

Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наяд төгрөгийн цогц төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд газар тариалангийн салбарыг дэмжих замаар хүнсний ногооны хангамжийн тогтвортой байдлыг хангахын тулд газар тариалан эрхлэгчдэд 100 тэрбум төгрөгийн хүүгийн хөнгөлөлттэй зээлийг олгохоор шийдвэрлэсэн.

Хөнгөлөлттэй зээлийг олгох шийдвэрийн дагуу хүүгийн хөнгөлөлтөд шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэж, улмаар 6 арилжааны банктай хамтран ажиллах гэрээ байгуулж, зээл олгох ажлыг эхлүүлээ.



100 ТЭРБУМ ₮

ХҮҮГИЙН ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ



ЭДИЙН ЗАСГАА
СЭРГЭЭХ ЗОРИЛТЫН
ХҮРЭЭНД

“ 100 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосноор хаврын тариалалт, намрын ургац хураалтыг хэвийн хэмжээнд явуулах нөхцөл бүрдэж, хүн амын хүнсний ногооны хэрэгцээг тогтвортой хангах нөхцөл бүрдэнэ. ”

”





ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙГ БАРИХ АЖИЛ ЯВАГДАЖ БАЙНА

ЭДИЙН ЗАСГАА
СЭРГЭЭХ ЗОРИЛТЫН
ХҮРЭЭНД



дотоодын
хэрэгцээг
хангана



1 ТЭРБУМ \$

гадаад худалдааны
алдагдлыг бууруулна

Дорноговь аймгийн Алтанширээ суманд жилд 1.5 сая тонн түүхий тос боловсруулах хүчин чадалтай Газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж, 2023 онд ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

Үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажил (инженерчлэл, зураг төсөл, худалдан авалт, барилга угсралт–EPC)–ыг багцуудад хуваан хэрэгжүүлэхээр БНЭУ–ын Эксим банк, төслийн менежментийн зөвлөх компанитай хамтран шийдвэрлэсний дагуу үйлдвэрийн технологийн бус байгууламж EPC–I, анхдагч процессын байгууламжууд болон үйлдвэрийн дэд бүтэц, хангамжийн байгууламж EPC–II, үйлдвэрийн цахилгаан станц EPC–III, лицензтэй технологийн байгууламж EPC–IV гэсэн дарааллаар ажлууд явагдана.

Өнөөдрийн байдлаар үйлдвэрийн талбайд төслийн менежментийн зөвлөх компанийн 4 хяналтын инженер, JMC Projects India компанийн 74 энэтхэг инженер, техникийн ажиллагсад, тус компанийн Монголын талаас авсан туслан гүйцэтгэгч 5 компанийн 78 хүн ажиллаж байна.

2,632 тэрбум ₮

үйлдвэрлэлийг
нэмэгдүүлнэ

199 тэрбум ₮

төсвийн тэнцлийг
сайжруулна

600

ажлын байрыг
нэмэгдүүлнэ

Технологийн бус байгууламжийн ажил (EPC–1) эхэлж Технологийн байгууламжуудын барилга угсралтын ажлын (EPC–2, (EPC–3) Ерөнхий гүйцэтгэгчийн урьдчилан сонгон шалгаруулалтад тэнцсэн компаниудаас эцсийн шалгаруулалт явагдаж байна.

Газрын тос боловсруулах үйлдвэрт шаардагдах усыг Бор хөөврийн говиос дамжуулах хоолой барих ажлыг эхлүүлээ.

Усны агуулахын суурийн ухалт, үерийн ус зайлуулах системийн барилга–угсралтын ажлыг 2021 оны 3 дугаар 15–ны өдрөөс эхлүүлээд байна. Үйлдвэрийн түүхий усны нөөцийн савны газар шорооны 65,000 м³ ухмалын ажил, нийт талбайд хэмжилтийн ажлыг гүйцэтгэж дууссан. Авто замын доор хийгдэх сувагчлалын ажлууд хийгдэж эхлээд байна.

Газрын тос дамжуулах хоолой барих ажлын гүйцэтгэгчийг сонгох олон улсын сонгон шалгаруулалтын ажлыг эхлүүлж, сонирхол илэрхийлсэн 9 орны 24 компаниас үнэлгээг хийж, 21 компанийг хураангуй жагсаалтад оруулаад байна.




НҮҮРС БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХ АЖЛЫГ ЭХЛҮҮЛЭХЭЭР ТОГТОВ

2021–2023 онд нийт 30 сая тн нүүрс баяжуулах хүчин чадал бүхий үйлдвэрийн 1 дүгээр модуль буюу 10 сая тоннын үйлдвэрийг ашиглалтад оруулна. 2025 оноос хойш 439 сая ам.доллар хөрөнгө оруулалт хийж, нүүрс баяжуулах үйлдвэрийн 20 сая тоннын хүчин чадалтай 2, 3 дугаар модулийг ашиглалтад оруулахаар төлөвлөж байна.

Монгол Улсын стандарт шаардлага хангасан төслийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлыг ШУТИС–ын харьяа Уул уурхайн хүрээлэн боловсруулан дууссан.

Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2021 оны 4 дүгээр сарын 1–ний өдрийн өргөтгөсөн хурлаар “Эрдэнэс Тавантолгой” ХК–ийн нүүрс баяжуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийг хэлэлцэн хүлээн авсан.

Улмаар 2021 оны 4 дүгээр сарын 28–ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар Тавантолгойн нүүрсний баяжуулах үйлдвэрийг 2021 оны гуравдугаар улиралд багтаан барьж эхлүүлэхээр тогтлоо.

 **208** сая \$
улс, орон нутгийн төсөвт
төвлөрүүлнэ

 **1,000**
ажлын байр шинээр
бий болно

 нэмүү өртөг шингэсэн
бүтээгдэхүүн экспортолно

ЭДИЙН ЗАСГАА СЭРГЭЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

“
Үйлдвэрт Тавантолгойн ордын
коксжих, сул коксжих нүүрсийг
баяжуулж, хатуу коксжих
нүүрсний баяжмал, хагас зөөлөн
коксжих нүүрсний баяжмал,
мидлингийг гаргаж, дэлхийн
зах зээлд нийлүүлнэ.”



ЗЭС ХАЙЛУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ДЭД БҮТЦИЙН АЖЛЫГ ЭХЛҮҮЛЛЭЭ

ЭДИЙН ЗАСГАА
СЭРГЭЭХ ЗОРИЛТЫН
ХҮРЭЭНД

124
мянган тн/жил
Cu

15
мянган тн/жил


12
мянган тн/жил
SO₂

Эрдэнэт үйлдвэр Төрийн өмчит үйлдвэрийн газарт үйлдвэрдэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, паркийн хүрээнд Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулахаар тогтож, дэд бүтцийн ажлыг эхлүүлэв.

Катодын зэс, зэсийн баяжмал	Цуггамал	Резин	SX/EW Катодын зэс	Эмульсын тэсрэх бодисын үйлдвэр
				
124,100 тн/жил	5,500 тн/жил	140 тн/жил	10,000 тн/жил	12,000 тн/жил



Зах зээлд өрсөлдөх чадвартай, дэвшилтэт технологид суурилсан аж үйлдвэрийн кластерыг хөгжүүлнэ. Уурхай даган байгуулагдсан Эрдэнэт хот цаашдаа бие даан тэлэн хөгжих боломжийг бүрдүүлнэ.

Улсын болон орон нутгийн төсвийн орлого, экспортын орлого нэмэгдэнэ. Шинээр 231 ажлын байр бий болно.


ХӨШИГИЙН ХӨНДИЙ ОРЧМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ШИНЭ БҮСИЙН СУУРЬ СУДАЛГААГ ЭХЛҮҮЛЛЭЭ

Улсын Их Хурлын 2020 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 55 дугаар тогтоолоор олон улсын нисэх онгоцны буудлыг түшиглэн эдийн засгийн тодорхой салбаруудыг тогтвортой хөгжлийн зорилтод нийцүүлэн хөгжүүлэх, хүн амыг эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх, үйлдвэрлэл, тээвэр логистик, аялал жуулчлалыг дэмжих зорилгоор Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт орон нутгийн зэрэглэлтэй “Шинэ Зуунмод”, “Майдар” хотуудыг шинээр байгуулахаар шийдвэрлэсэн.

Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд баригдсан Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг даган хөгжих “Шинэ Зуунмод” хот болон Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Засгийн газрын 2019 оны 29, 30 дугаар тогтоолоор тус тус батлан хэрэгжүүлж байна. Энэ төлөвлөгөөний дагуу Хөшигийн хөндий орчмын эдийн засгийн хөгжлийн шинэ бүсийн суурь судалгааг эхлүүлээ. “Майдар” эко хотын хөгжлийн концепцийг орон нутгийн онцлог, цаг уурын нөхцөлтэй уялдуулан тогтвортой, нүүрс төрөгчийн ялгарал багатай, байгаль орчинд ээлтэй хот байхаар төлөвлөөд байна.

ЭДИЙН ЗАСГАА СЭРГЭЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

Дагуул хотуудад хот байгуулалтын болон зам тээврийн дэд бүтцийг цогцоор нь төлөвлөж хөгжүүлснээр гадаад, дотоодын хөрөнгө оруулалт нэмэгдэж, эдийн засгийн тогтвортой өндөр өсөлтийн шинэ бүс бий болно.



Суурьшлын нэр	2020 он	2040 он
ЗУУНМОД ХОТ	17,000	70,000
ШИНЭ ЗУУНМОД ХОТ		34,000
МАЙДАР ХОТ		40,000
СЭРГЭЛЭН СУМ	2,000	4,000
Нийт хүн ам	19,000	148,000



→ **60-70**
мянган ажлын байр

ДНБ ↑ **10-15%**

“БАЙГАЛИЙН ХИЙН ХООЛОЙ” ТӨСЛИЙН АЖЛЫГ ЭРЧИМЖҮҮЛЛЭЭ

ЭДИЙН ЗАСГАА СЭРГЭЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД



Байгалийн хийн хоолойн төсөл хэрэгжсэнээр жилд байгалийн хий дамжуулсны түрээсийн төлбөр ойролцоогоор 500–800 сая ам.доллар Монгол Улсын төсөвт орно. Мөн түүнчлэн төслийн барилгын ажил явагдах хугацаанд 3,000 гаруй монгол хүн ажиллаж, ашиглалтын явцад 800 орчим хүний байнгын ажлын байр, 5,000 гаруй хүний дам ажлын байр бий болно гэсэн төсөөлөлтэй ажиллаж байна.

50 тэрбум м³

ОХУ-аас БНХАУ руу жилд дамжуулах хий

МАРШРУТ

“Наушки” – “Сүхбаатар” –
“Дархан” – “Сайншанд” –
“Замын-Үүд” – “Эрэн”

Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 12 дугаар сард ОХУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр Монгол Улсын Шадар сайд болон ОХУ-ын “Газпром” НХН-ийн Удирдах зөвлөлийн дарга нар Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан ОХУ-аас БНХАУ руу байгалийн хийн хоолой барих боломжийг хамтран судлах тухай “Ойлголцлын санамж бичиг”-т гарын үсэг зурсан нь энэхүү төсөл бодитой хэрэгжих эхний алхам болсон билээ.

“Эрдэнэс Монгол” ХХК төслийн хэрэгжилтийг ханган, монголын талыг төлөөлөн ОХУ-ын “Газпром” НХН болон БНХАУ-ын “Үндэсний газрын тос, байгалийн хийн корпораци”-тай хамтран ажиллаж байна. Энэхүү төсөл нь 4–5 жилийн хугацаанд хэрэгжих бөгөөд хамтрагч талуудын 100 хувийн хөрөнгө оруулалтаар хийгдэнэ.

Талууд 2021 онд багтаан техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж дуусгах шахуу зорилттой ажиллаж байгаа бөгөөд энэ хүрээнд техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах үүрэг бүхий тусгай зориулалтын компани болох “Газопровод Союз Восток” ХХК 2021 оны 1 дүгээр сард улсын бүртгэлд бүртгүүлэн, үйл ажиллагаагаа эхлүүлээд байна.

“Газпром” НХН-ийн төлөөлөгчид байгалийн хийн хоолойн урьдчилан төлөвлөгдөж байгаа маршрутын дагуу агаарын болон газрын тандалт судалгаануудыг зохион байгуулан ажилласнаар төслийн хэрэгжих нөхцөл байдлыг бодитойгоор, нааштайгаар үнэлэх боломж гарсан гэж дүгнэж байна.

ЦАХИМ ВИЗИЙГ ЭНЭ ОНЫ 6 ДУГААР САРААС ЭХЛЭН ОЛГОХООР БОЛЛОО

Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр цахим виз олгох хуулийн зохицуулалт хийгдсэн ба “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар энэ оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхлэх юм.

Монгол Улсад аялал жуулчлал, урлаг спортын арга хэмжээнд оролцох, транзит дамжин өнгөрөх гэх мэт шалтгаанаар ирж буй гадаадын иргэдийн урсгалыг нэмэгдүүлэх орон зай, цаг хугацаанаас хамааралгүйгээр цахимаар болон хуульд заасан бусад хэлбэрээр визийн үйлчилгээг хялбар шуурхай үзүүлэх боломжийг бүрдүүлэх, давхардал, зөрчлийг арилгах зорилготойгоор визийн мэдээллийн нэгдсэн санг бий болгохоор ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 63 дугаар захирамжийн дагуу Монгол Улсын цахим виз нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангах, холбогдох журмын төслүүдийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.



Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд визийн мэдээллийн нэгдсэн санг бий болгох, цахимаар виз олгох системийг боловсруулан нэвтрүүлж, 2021 оны 6 дугаар сард ашиглалтад оруулна.

✓ Цахим визийн системийн ажлын даалгаврын төслийг боловсруулж, нууцлал, аюулгүй байдал, цахим төлбөр тооцооны асуудлаар холбогдох байгууллагын мэдээлэл, зөвлөмжид нийцүүлэн батлав.

✓ Мэдээллийн технологи, цахим системийн чиглэлээр 10-аас дээш жил ажилласан туршлагатай, мэргэжлийн ур чадвар бүхий дотоодын аж ахуйн нэгжүүдээс санал авч, гүйцэтгэгч компанийг сонгон шалгаруулав.

ЭДИЙН ЗАСГАА СЭРГЭЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД



- АЛБАН АЖЛААР
- ХУВИЙН ЖУРМААР
- АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ
- АЖИЛЛАХ
- СУРАЛЦАХ
- БАЙНГА ОРШИН СУУХ
- БУСАД



ТОГТВОРТОЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЛЭЭ

ЭДИЙН ЗАСГАА СЭРГЭЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД



Ховд аймагт:

- ⇒ “Нүүдэлчдийн соёлын аялал жуулчлалын цогцолбор” болон “Жуулчны гудамж”

Баян-Өлгий аймагт:

- ⇒ “Уулын авиралтын отоглох цэг”-ийг 3 байршилд, Монгол Алтайн хадны зургийн цахим музей,

Увс аймагт:

- ⇒ “Үндэсний спортын цогцолбор”, “Жуулчны гудамж” болон тусгай хамгаалалттай бүс нутгийн 5 цэгт баригдах отоглох цэг, төлбөр хураах цэг болон шувуу ажиглах цэгүүдийг тохижуулна.



Азийн хөгжлийн банкны 38 сая ам.долларын санхүүжилтээр “Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл-I”-ийг Хөвсгөл, Хэнтий аймагт 2019–2024 онд, 32 сая ам.долларын санхүүжилтээр “Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл-II”-ийг Баян-Өлгий, Увс, Ховд аймгуудад 2021–2027 онд хэрэгжүүлж байна.

“Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл-I”-ийн хүрээнд Хөвсгөл аймагт Жанхай-Тойлогтын чиглэлийн 35.9 километр хатуу хучилттай авто зам, 450 автомашин, 45 автобусны багтаамж бүхий авто зогсоол баригдана. Хэнтий аймагт “Чингис хаан цогцолбор” байгуулахаар зураг, төслийг эцэслэн боловсруулаад байна.

Баян-Өлгий, Ховд, Увс аймгуудад 2021–2027 онд хэрэгжих “Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл-II”-ын техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлыг Азийн хөгжлийн банкттай зөвшилцөн эцэслэлээ.

Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн хүрээнд орчны бүсийн 13 сумын 3,700 орчим өрхийн 16,000 иргэд шууд ба шууд бус байдлаар үр шимийг хүртэж 1,350 орчим ажлын байраар хангагдана.



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАР ДАХЬ ЦАХИМ ШИЛЖИЛТ

Байгаль орчин аялал жуулчлалын яам, “Айхотел” ХХК-тай хамтран Ковид-19 цар тахлын хүндхэн нөхцөл байдлын үед иргэд, жуулчдад хөнгөлөлттэй үнээр амралтын газар, жуулчны бааз, зочид буудлуудад захиалга хийх боломжийг бүрдүүлэн “Хямд амар” аялал жуулчлалын цахим үзэсгэлэнг 2021 оны 1 дүгээр сарын 27-ны өдрөөс 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн хооронд зохион байгууллаа.

Үзэсгэлэнгийн хугацаанд Улаанбаатар хот, 21 аймгийн аялал жуулчлалын байгууллагууд бүтээгдэхүүн, үйлчилгээ болон байгаль, түүх, соёлын өв бүхий жуулчдын зорих газруудыг сурталчилна.



ЗАХИАЛГА

1,139



ҮНИЙН ДҮН

207 Сая ₮

ЭДИЙН ЗАСГАА
СЭРГЭЭХ ЗОРИЛТЫН
ХҮРЭЭНД

“

Иргэдэд даатгалтай аялал, амралтыг урьдчилан хөнгөлөлттэй үнээр захиалаад 2022 он хүртэл хүссэн үедээ амрах боломжийг бүрдүүлж өгсөн.

”

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ



ХАНРАГЧ БАЙГУУЛЛАГУУД



НИСЭЭМИЙН АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР



Х Я М Д
АМАР
online expo

2021/01/27-
2021/03/01

БҮН ЮМ САЛХАН БОЛНО



СОЁЛЫН БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИЙГ БОЛОВСРУУЛАВ

ЭДИЙН ЗАСГАА СЭРГЭЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД



- ✓ Бүтээлч үйлдвэрлэлийн эдийн засагт эзлэх хувийг өсгөх;
- ✓ Олон улсын зах зээлд гарахад дэмжлэг үзүүлэх;
- ✓ Дэлхийд өрсөлдөх Монгол Брэндийг хөгжүүлэх;
- ✓ Импортыг орлох чадамжийг өсгөх;
- ✓ Жуулчдын урсгалыг татах.



Алсын хараа–2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2020–2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт зааснаар соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлийг тодорхойлж, хөгжлийн стратегийг боловсрууллаа.

Салбарт хамаарах үйл ажиллагаа, харилцан уялдаа хамаарлыг авч үзэн, Монгол Улсын Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбарын хүрээг шинэчлэн тодорхойллоо. Ингэхдээ:

- ➔ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (UNESCO), Нэгдсэн Үндэстний Байгууллагын Худалдаа хөгжлийн бага хурал (UNCTAD)–ын арга зүй, зөвлөмжийг үндэслэн,
- ➔ Англи, Солонгос зэрэг соёлын бүтээлч үйлдвэрлэлийг амжилттай хөгжүүлж байгаа улс орнуудын туршлагад суурилан,
- ➔ Эрдэмтэн, судлаач, уран бүтээлчид, соёл урлагийн болон бизнесийн салбарын төлөөлөлтэй 16 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, 255 эксперттэй уулзалт хийж, Монгол Улсын соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хамаарал бүхий дараах 13 чиглэлийг тогтоов.

<p>1.ӨВ СОЁЛ</p> <p>Монгол судлал, хэл бичиг, соёл судлал, түүх археологи, антропологи, биет өвийг хамгаалах, сэргээн засах, биет бус өвийг хадгалах, дэлгэрүүлэх</p>	<p>2. УТГА ЗОХИОЛ</p> <p>Уран зохиолын бүтээл, шүүмж судлал, хэвлэн нийтлэх үйл ажиллагаа, редакторлах, хэвлэлийн эх бэлтгэх, хэвлэх, номын худалдаа, цахим аудио ном, номын сан</p>	<p>3. ДҮРСЛЭХ УРЛАГ</p> <p>Дүрслэх урлагийн бүх чиглэл, уран зураг, уран баримал, хайчилбар, хатгамал, урлан, студи, үзэсгэлэн, гэрэл зураг түүнтэй холбоотой үйл ажиллагаа</p>	<p>4.ДУУ ХӨГЖИМ</p> <p>Дуун үг, ая зохиогчид, хөгжмийн зохиолчид, хамтлаг дуучид, хөгжимчид, филармони, найрал хөгжим, дуу дүрс бичлэгийн студи, продакшн, рекордс, тоглолт зохион байгуулах</p>	<p>5.ТАЙЗНЫ УРЛАГ</p> <p>Театр, дуурь, балет, мюзикл, концерт, гэрлийн шоу, дууны шоу, хүүхэлдэй, гал наадам, цирк, хошин урлаг</p>
<p>6. КИНО УРЛАГ</p> <p>Арилжааны кино, баримтат түүхэн кино, дуу дүрс бичлэгийн студи продакшн, кино павильон, гэрэлтүүлгийн үйлчилгээ, кинотеатр, кино видео сан</p>	<p>7. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ДИЗАЙН</p> <p>Арилжааны кино, баримтат түүхэн кино, дуу дүрс бичлэгийн студи продакшн, кино павильон, гэрэлтүүлгийн үйлчилгээ, кинотеатр, кино видео сан</p>	<p>8. ХУВЦАС ЗАГВАР</p> <p>Хувцас, дагалдах хэрэгслийн загварын шийдэл, материал, технологийн судалгаа, үйлдвэрлэл, хувцас загварын студи, бьютик, салон, загварын шоу, уралдаан тэмцээн, үзүүлбэр, загвар өмсөгчдийн сургалт, агентлаг.</p>	<p>9. ГРАФИК ДИЗАЙН</p> <p>Хэрэглэгчийн интэрфэйс график дизайн, хэвлэлийн график дизайн, хөдөлгөөнт график дизайн, тоглоом, анимэйшн, брендинг, сурталчилгаа, сав баглаа боодлын график дизайн, бусад график дизайн</p>	<p>10. ИНТЕРЬЕР ДИЗАЙН</p> <p>Интерьер дизайны төлөвлөлт, шийдэл, засал чимэглэл</p>
<p>11. АРХИТЕКТУР</p> <p>Хот төлөвлөлт, ландшафт, орчны төлөвлөлт, барилга архитектур–барилга байгууламжийн архитектур төлөвлөлт</p>	<p>12. МАРКЕТИНГ, БРЭНДИНГ, КОММУНИКАЦИ</p> <p>Маркетинг, брэндигийн агентлаг, маркетингийн судалгааны агентлаг, зар сурталчилгааны агентлагууд</p>	<p>13. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, РАДИО, ТЕЛЕВИЗ</p> <p>Сонин сэтгүүл, телевиз, радио, мэдээллийн агентлаг, мэдээллийн цахим хуудас</p>		

СОЁЛЫН БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЦОГЦОЛБОР БАЙГУУЛНА

Соёлын бүтээлч үйлдвэрлэл, “Монгол соёл, Монголын баялаг” цогц арга хэмжээний хүрээнд Засгийн газрын 2021 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн хуралдаанаар “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор” байгуулах төслийг хэлэлцэв.

Тус цогцолбор нь соёлын бүтээлч үйлдвэрлэлийн бүх талын оролцогчдыг төвлөрүүлсэн соёлын хүрээлэн байх бөгөөд иргэдийн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх орон зай байхын зэрэгцээ, шинэ санаа шилдэг бүтээл бүхий гарааны бизнесийг өсгөн бойжуулах инкубатор орчин болно.



ЭДИЙН ЗАСГАА
СЭРГЭЭХ ЗОРИЛТЫН
ХҮРЭЭНД



АЖЛЫН БАЙР

шинээр бий болгох
боломжтой



ТАВАНТОЛГОЙ–ЗҮҮНБАЯН ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

ЭДИЙН ЗАСГАА СЭРГЭЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД



Уг төмөр замаар жилд 15 сая тонн орчим уул уурхайн бүтээгдэхүүнийг бага зардлаар, богино хугацаанд (авто тээвэртэй харьцуулахад) тээвэрлэж, эскпортлох боломж бүрдэнэ.



348 тэрбум ₮
үйлдвэрлэлийг
нэмэгдүүлнэ


1,000
ажлын байрыг
нэмэгдүүлнэ

37
төмөр замын трасс дагуух
ордуудыг ашиглана

Тавантолгой–Зүүнбаян чиглэлийн төмөр зам нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Таван толгойн нүүрсний ордоос Дорноговь аймгийн Зүүнбаян чиглэлд баригдах бөгөөд төмөр замын урт нь 416.2 км үргэлжлэх бөгөөд төмөр замын голын даац нь 25 тонн, царигийн хэмжээ 1,520 мм байна.

Тавантолгой–Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн газар шорооны ажил болох хөрс хуулах, далан босгох, сэтэрхий гаргах зэрэг 25.1 сая шоо метр газар шорооны ажил, ус өнгөрүүлэх, зайлуулах 595 ширхэг дөрвөлжин, дугуй хоолой, ус хангамжийн 43 худаг гаргах, 6 зөрлөгийн барилгын ажил бүрэн дууссан. Өртөөний 1 барилга 76 хувийн, 27 байршилд баригдах нийт 2.4 км урттай гүүрийн ажлын барилга угсралт 95.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

Дээд бүтцийн 416.2 км гол зам, 46.6 км өртөөний зам угсрахаас “Улаанбаатар төмөр зам” Хувь нийлүүлсэн нийгэмлэг, Зэвсэгт хүчний жанжин штаб хамтран 90 хувийн барилга угсралтын ажлыг гүйцэтгээд байна. Мөн 455.5 км цахилгаан дамжуулах агаарын шугамын ажлын гүйцэтгэл 87.2 хувьтай байна. Энэ төмөр замд шаардлагатай 842.6 мянган ширхэг төмөр бетон дэрийг Монголын компаниуд 100 хувь үйлдвэрлэлээ. Нийт 890 мянган шоо метр балласт бэлтгэхээс 78.5 хувийг буюу 698.9 мянган шоо метрийг бэлтгэн ажиллаж байна. Одоо дээд бүтцийн ажлын угсралт, чигжилтийн болон тохируулгын ажлууд үлдээд байна. Энэ оны 2 дугаар улиралд багтаан тус төмөр замыг барьж, ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Цаашид Зүүнбаян–Ханги, Сайншанд–Баруун–Урт–Хөөт чиглэлийн төмөр замын төслүүд хэрэгжиж эхэлвэл эдгээр төмөр замуудтай холбогдож, үндэсний төмөр замын сүлжээ өргөжиж, эдийн засгийн хөгжлийг бүс нутгуудад дэлгэрүүлэх боломжууд нээгдэнэ.




ТАВАНТОЛГОЙ–ГАСУУН СУХАЙТ ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

Тавантолгой–Гашуунсухайт чиглэлийн төмөр зам Өмнөговь аймгийн Цогтцэций, Баян-Овоо, Ханбогд сумын нутаг дэвсгэрт байрлах бөгөөд Тавантолгой уурхайгаас Гашуунсухайт боомт хүртэл 240 орчим километр гол замтай, 2 өртөө, 5 зөрлөгтэй байх юм. Уг төмөр зам баригдсанаар манай улс жилдээ 30 сая тонн коксжих болон эрчим хүчний нүүрсийг тээвэрлэн экспортлох боломжтой.

Төмөр замын гол шугамын 208.5 километр уртад замын доод бүтэц 100 хувь, 207 километр төмөр замын дээд бүтцийн ажил 64.7 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Төмөр замын ДТХ-ын байгууламж, эрчим хүчний багц ажлын зураг төслийн ажил хийгдэж байна. Гашуунсухайт хил орчмын 30.85 километр урт гол замын ажлын газар шорооны ажил 47.5 хувь, Тавантолгой уурхайн ачилтын тойргийн газар шорооны ажил 88.8% хувийн гүйцэтгэлтэй байна. Уг чиглэлийн төмөр замыг 2022 оны II улиралд багтаан ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

Транзит болон экспортын ачааг Хятадын нутаг, түүний далайн боомт мөн гуравдагч орны зах зээл рүү тээвэрлэх боломжтой.

Төмөр замын барилгын ажил болон ашиглалтын үйл ажиллагаатай холбогдон өмнөд бүсийн орон нутагт шинээр түр болон 1,900 орчим байнгын ажлын байр бий болж, иргэд мэргэжилтэй, ажилтай, орлоготой болох нөхцөл бүрдэнэ.



ЭДИЙН ЗАСГАА СЭРГЭЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД



Монгол Улсын нутаг дэвсгэрээр тээвэрлэх одоо байгаа авто замын ачаа тээврийн тариф тонн тутам 32 ам.доллараас 8 ам.доллар болж, 75 хувиар буурна.

Хэрэв төмөр зам ашиглалтад орсон бол нүүрс тээврийн тариф тонн тутмаас 24 ам.долларын хэмнэлт гарах бөгөөд жилд 430 сая ам.доллар болно.

Нүүрс экспортоос жил тутам 2.3 тэрбум ам.доллар, төмөр замын тээврээс 227 сая ам.долларын орлогыг бүрдүүлэх боломж бүрдэнэ.

Жилдээ 30 сая тонн ашигт малтмал болон бусад ачааг тээвэрлэн экспортлоно.

348 тэрбум ₮

үйлдвэрлэлийг
нэмэгдүүлнэ

1,900

ажлын байрыг
нэмэгдүүлнэ





БОГДХАН ТӨМӨР ЗАМЫН ТӨСЛИЙГ ЭХЛҮҮЛЭХЭЭР ШИЙДВЭРЛЭВ

ЭДИЙН ЗАСГАА СЭРГЭЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

Богдхан төмөр замын төсөл нь Монгол–Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийн гол замаас Мандал өртөөнөөс салаалан Богдхан уулын урдуур тойрч Багахангай өртөөнд холбогдох чиглэлтэй төмөр замын төсөл юм.

Богдхан төмөр замын урьдчилсан т судалгааны ажил 2010 онд хийгдсэн бөгөөд уг төсөл хэрэгжсэнээр төмөр замын дамжин өнгөрөх болон бусад экспорт, импортын ачаа тээврийг Богд уулын урдуур тойруулж, нийслэл дундуур өнгөрүүлэлгүй аялуулна. Төмөр замын одоогийн шугамыг зорчигчийн галт тэрэг аялуулах, хот дүүргийн нийтийн зорчигч тээвэрт ашиглах боломж бүрдэнэ.

“Богдхан төмөр зам” төслийн хэрэгжилтийг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 76 дугаар захирамжаар байгуулан төслийг хэрэгжүүлэх ажлын ерөнхий төлөвлөгөөг боловсрууллаа.

- ➔ *Ачаа тээвэрлэлтийг жилд 5–6 сая тонноор нэмэгдүүлнэ.*
- ➔ *Галт тэрэгний хурд нэмэгдэнэ.*
- ➔ *Зам ашиглалтын зардал буурна.*



Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулж, аюулгүй байдлыг сайжруулж, дуу, шуугианы бохирдол багасч, нийслэлд нийтийн тээврийн шинэ урсгал бий болж, зорчигч тээврийн нэгдсэн терминал байгуулагдах бөгөөд төмөр замын ачааны терминал, салаа замууд болон барилга байгууламжийн дагуух газарт дахин төлөвлөлт хийгдэнэ.



УЛААНБААТАР – АРВАЙХЭЭР ЧИГЛЭЛИЙН АВТО ЗАМЫН ИХ ЗАСВАРЫН АЖЛЫГ ЭХЛҮҮЛЛЭЭ



Улаанбаатар – Арвайхээр чиглэлийн улсын чанартай авто замын 371–431 километр дэх хэсэг буюу Хүйтний хөндийгөөс аймгийн Цагаан хаалга хүртэлх 57.56 км замыг засварлах, шинэчлэх ажлыг эхлүүлээ.

Азийн хөгжлийн банкны “Бүс нутгийн авто зам хөгжүүлэх засвар арчлалтын төсөл”-ийн хүрээнд хэрэгжүүлэх уг авто замыг анх 2001 онд ашиглалтад оруулснаас хойш 19 жилийн хугацаанд засвар хийгдээгүй бөгөөд ихээхэн эвдрэл үүсэж, ашиглалтын нөхцөл байдал муудсан. Гүйцэтгэгчийг Азийн хөгжлийн банкны “Худалдан авах ажиллагааны журам”-ын дагуу сонгон шалгаруулж, гэрээ байгуулан ажлыг эхлүүлээд байна. Тус чиглэлийн авто замын их засварын ажлыг гүйцэтгэх бөгөөд 40 км замыг суурь хучилттай солих, эвдрэл ихтэй хэсгүүдийн суурь хөрсийг солих, далан барих, 56 цэгийн хоолойг солих, 8 цэгт хоолой барих бөгөөд 2022 онд ашиглалтад оруулна.

Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрөөс ажлыг эхлүүлээд байна. Гүйцэтгэгч нь зам барилгын бэлтгэл ажлыг шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг нүүлгэн шилжүүлж, ажилчдын кемп байгуулах, улаан шугам хүлээлцэх зэрэг бэлтгэл ажлын 40 хувийг хангаад байна.

ЭДИЙН ЗАСГАА СЭРГЭЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД



Баруун 5 аймгийг нийслэл хоттой холбох улсын чанартай авто замын гол чиглэл, хоногт явах хөдөлгөөний эрчим өндөртэй зам тул бүс нутгийн замын аюулгүй байдал, замын нөхцөл, нэвтрэх хүчин чадал сайжирна.





УЛААНБААТАР – ДАРХАН ЧИГЛЭЛИЙН АВТО ЗАМЫН ТӨСЛИЙГ ЭРЧИМЖҮҮЛЛЭЭ

ЭДИЙН ЗАСГАА
СЭРГЭЭХ ЗОРИЛТЫН
ХҮРЭЭНД

Улаанбаатар – Дархан чиглэлийн авто зам нь Төв Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны хөтөлбөр, ОХУ – Монгол Улс – БНХАУ-ын худалдааны чухал ач холбогдол бүхий коридор юм. Тус замыг “Asia Highway 3” стандартын нэгдүгээр зэрэглэлийн 4 эгнээ бүхий зам болгохоор ажиллаж байна.

Тус ажлын хүрээнд Улаанбаатар – Дархан чиглэлийн 204.11 километр замыг шинэчлэх, 202.4 километр авто замын өргөтгөл хийх төслүүд хэрэгжиж байна.

Зам шинэчлэх ажлын хүрээнд 113.5 километр замын далан, хоолой, дэд суурь болон цементээр бэхжүүлсэн суурийн доод үе барьсан. 68.92 километр замыг цементээр бэхжүүлсэн суурийн дээд үе ба 65.03 километр замын асфальт хучилт тавьсан.

Замын өргөтгөл хийх зам, барилгын ажил 2020 оны 3 дугаар сарын 15-ны өдрөөс эхэлсэн, гүүр хоолой, зурвас газрын хөрс хуулах, ухмал ба далан байгуулах ажил хийгдэж байна.

УЛААНБААТАР–ДАРХАНЫ ЗАМЫН ШИНЭЧЛЭЛИЙН АЖЛЫН ЯВЦ, БАГЦААР



2 болон 4 дүгээр багцын ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг дахин зохион байгуулах ажил хийгдэж байна.



ОХУ, БНХАУ-ыг Улаанбаатараар дайруулан холбосон, Төв Азийн Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны байгууллагын Коридор 4b-н нэг хэсэг болох хөдөлгөөний эрчим ихтэй авто замын бэлэн байдал хангагдаж, зорчигчид саадгүй аваар осолгүй зорчих нөхцөлийг бүрдүүлнэ. Мөн тухайн замаар явах ачаа эргэлт өсөж, авто машины элэгдэл хорогдол, шатахуун зарцуулалт эрс багасна. Түүнчлэн орон нутагт амьдарч буй иргэдэд бизнесийн шинэ орчинг бүрдүүлж, орон нутагт байнгын болон түр ажлын байрыг бий болгох, цаашлаад ядуурлыг бууруулахад шууд бус байдлаар нөлөөлөх ач холбогдолтой юм.



ТАВАНТОЛГОЙН ЦАХИЛГААН СТАНЦ БАРИХ ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТИЙГ ШИЙДВЭРЛЭЛЭЭ

Тавантолгойн нүүрсний ордыг түшиглэн 450 МВт-ын суурилагдсан хүчин чадалтай дулааны цахилгаан станц, 220 кВ-ын 2 хэлхээ 141 км ЦДАШ, 220 кВ-ын дэд станцыг 2025 онд ашиглалтад оруулна. Тус станц нь жилд 3,150 сая кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх ба Оюутолгойн өсөн нэмэгдэх 2,242.5 сая кВт.ц хэрэглээ болон Тавантолгойн орд газрууд, бусад стратегийн ач холбогдол бүхий өмнөд бүсийн уул уурхайн төслүүдийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг дотоодоос хангана.

Төслийн техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн. Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанаар Тавантолгой ДЦС ТӨХХК-ийн хувь эзэмшлийн асуудлыг хэлэлцэн, Эрдэнэс Тавантолгой ХК-д компанийн хувьцааны 30 хувийг эзэмшүүлэх замаар төслийн нийт хөрөнгө оруулалтын 30 хувийг шийдвэрлэсэн.

Үлдэгдэл 70 хувийн санхүүжилтийг төслийн санхүүжилтийн хэлбэрээр санхүүжүүлэхээр эцэслэн шийдвэрлэлээ.



ЭДИЙН ЗАСГАА СЭРГЭЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД



Оюутолгойн БНХАУ-аас авч байгаа 110–130 сая ам.долларын импортын эрчим хүчийг орлох эх үүсвэр бий болох ба үүний зэрэгцээ жил бүр улсын төсөвт 34.0 сая ам.долларын татварын орлого бүрдүүлэх юм. Өмнийн говийн уул уурхайн эрчим хүчний хэрэглээг найдвартай эрчим хүчний эх үүсвэрээс хангах, цахилгаан станцын үйл ажиллагааны гол зардал болох нүүрс тээвэрлэлтийн зардлыг хэмнэх, цахилгаан дамжуулах агаарын шугамын алдагдлыг бууруулах, төслийн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой юм. Мөн коксжих нүүрсний олборлолтын үед хаягдаж буй бага илчлэгтэй эрчим хүчний нүүрсийг эдийн засгийн эргэлтэд оруулна.



3,150 сая

кВт/цаг жил



130 сая \$

импорт орлоно



300

ажлын байр



ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН СТАНЦЫН ТӨСЛИЙГ ЭХЛҮҮЛЛЭЭ

ЭДИЙН ЗАСГАА СЭРГЭЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД



ОХУ, БНХАУ-аас авч буй импортын эрчим хүчний төлбөр болох 17.5 тэрбум төгрөгийг хэмнэнэ. Дотоодын эрчим хүчний эх үүсвэр бий болсноор Баруун бүс, Алтай-Улиастай эрчим хүчний систем улсын төсвөөс эрчим хүчний үнийн зөрүүд төлдөг татаас авдаггүй болно. Жилд 366 сая кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх ба баруун таван аймгийн 253.3 сая кВт.ц хэрэглээ болон тус бүс нутгийн өсөн нэмэгдэх цахилгаан эрчим хүчний хэрэгцээг бүрэн хангана. Нийт 52,000 ахуйн хэрэглэгчдийг хангах шинэ эх үүсвэр бий болж, баруун 5 аймгийн 4,430 аж ахуйн нэгж, 5,400 орон сууц, 36,413 гэр хорооллын хэрэглэгчийг дотоодын цахилгаан эрчим хүчээр бүрэн хангана.



366 сая
кВт/цаг жил



17.5 тэрбум ₮
төсвийн хэмнэлт



52,000
айл өрх

Баруун бүс нь эрчим хүчний хэрэглээнийхээ 74 хувийг ОХУ, БНХАУ-аас импортоор 5–6 дахин өндөр үнэтэй эрчим хүчээр хангаж байна. Баруун бүсийн эрчим хүчний хэрэгцээг найдвартай эх үүсвэрээр хангах, импортын өндөр үнэтэй цахилгаан эрчим хүчийг дотоодын хямд эрчим хүчээр орлуулах, баруун бүсийн эрчим хүчний горим тохируулгын үүрэг гүйцэтгэх 90 МВт-ын хүчин чадалтай усан цахилгаан станцыг Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын Ховд гол дээрх Шижигтийн хавцалд 2025 онд барьж, ашиглалтад оруулах төслийн ажлыг эхлүүлээ.

Засгийн газрын 2018 оны 160 дугаар тогтоолоор БНХАУ-ын 1.0 тэрбум ам.долларын зээлийн хөрөнгөөс санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн.

Төслийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлах 2021 оны 5 дугаар сарын 17-ны өдөр нээхээр ажиллаж байна.

Төслийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг төслийн нөлөөлөлд өртөж буй Ховд аймгийн Эрдэнэбүрэн, Мянгад, Баян-Өлгий аймгийн Баяннуур, Увс аймгийн Өмнөговь сумын иргэдэд танилцуулж, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлнэ.



ЦАХИЛГААН ЦЭНЭГ ХУРИМТЛУУРЫН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ ЭХЭЛЛЭЭ

Төвийн эрчим хүчний системийн цахилгаан станцуудын горим тохируулгад нэн чухал ач холбогдолтой цэнэг хураагуурын станц нь өдөрт 160 МВт.ц цахилгаан эрчим хүчийг хуримтлуулах хүчин чадалтай бөгөөд 2023 онд ашиглалтад оруулна.

Азийн хөгжлийн банктэй байгуулсан санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрт 2020 оны 2 дугаар сард нэмэлт өөрчлөлт оруулж, УИХ-ын 2020 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн чуулганаар соёрхон батлуулсан.

Барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлахад бэлтгэж байна.

ЭДИЙН ЗАСГАА
СЭРГЭЭХ ЗОРИЛТЫН
ХҮРЭЭНД



//

Төвийн эрчим хүчний нэгдсэн системийн цахилгаан станцуудын горимыг тохируулснаар эрчим хүчний импортын хэмжээ буурна.

//



СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТӨСЛҮҮДИЙГ ЭХЛҮҮЛЛЭЭ

ЭДИЙН ЗАСГАА СЭРГЭЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД



*Тогтвортой хөгжлийн зорилт,
Уур амьсгалын өөрчлөлтийг
сааруулахад Монгол Улсын
оруулах хувь нэмрийг
нэмэгдүүлж, сэргээгдэх эрчим
хүчний буюу ногоон эрчим хүчний
үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.
Цахилгаан дамжуулах,
түгээх сүлжээний алдагдлыг
бууруулснаар хэрэглэгчдийн
цахилгаан, эрчим хүчний чанар,
хүртээмж сайжирч, ашиглалтын
зардал буурна.*




Баруун бүсийн эрчим хүчний системд Завхан аймгийн Улиастай суманд 5 МВт-ын хүчин чадалтай Нарны цахилгаан станц, Ховд аймгийн Мянгад суманд 10 МВт-ын хүчин чадалтай нарны цахилгаан станцыг барих ажлыг эхлүүлээ. Тус төслүүдийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан бөгөөд шалгарсан компанитай гэрээ байгуулж, барилгын ажлыг эхлүүлээд байна.

Мөн Дэлхийн банкны санхүүжилтээр “Цахилгаан түгээх сүлжээний алдагдлыг бууруулах төсөл” 2017 оноос хэрэгжиж байна. Төслийн хүрээнд цахилгааны 35/6–10 кВ-ын 10 МВА чадалтай дэд станц 3 ш, 6–10 кВ-ын хуваарилах байгууламж 3 ш, 6–10 кВ-ын дэд станц 47 ш, 6–10 кВ-ын агаарын болон кабель шугам 117 км, 0.4 кВ-ын агаарын болон кабель шугам 1,067 километр татаж, 76,532 ширхэг ухаалаг тоолуурыг 2022 онд суурилуулж дуусгана.

Төслийн нэгдүгээр үе шат 2018–2021 онд Архангай аймгийн төв Цэцэрлэг, Булган аймгийн төв Булган, Говьсүмбэр аймгийн төв Чойр хотууд болон нийслэлийн Багануур дүүрэгт хэрэгжиж, 85–100 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хоёрдугаар үе шатны төсөл 2021–2022 онд хэрэгжих бөгөөд үүнд, Эрдэнэт хот, Өвөрхангай аймгийн төв Арвайхээр, Хархорин сум, Дундговь аймгийн төв Мандалговь, Дорноговь аймгийн төв Сайншанд, Замын Үүд сум, Хэнтий аймгийн Хэрлэн, Бор-Өндөр сумдын төвийн цахилгаан түгээх сүлжээг иж бүрэн шинэчилнэ. Барилга угсралтын ажлыг гүйцэтгэгчдийг сонгон шалгаруулж, барилга угсралтын ажлыг эхлүүлээд байна.



УЛААНБААТАР ХОТЫН ДУЛААН ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ

Төслийн хүрээнд хотын төв зам дагуу 25 дугаар эмийн сангаас Драгон хүртэлх 3.8 километр хос 400 мм-ийн голчтой дулааны шугам, 1 иж бүрдэл насосны өргөх станцын чадлыг нэмэгдүүлж, Толгойт, III, IV хорооллын эцэс, Төмөр замын II анги орчмын шинэ төлөвлөлтийн бүсэд 11 километр хос 400 мм-ийн голчтой дулааны шугам шинээр татаж, Дулааны III цахилгаан станцаас Нарны гүүрний уулзвар хүртэлх 2.8 километр хос 800мм дулааны шугамыг 1000мм, Нарны гүүрний уулзвараас Тээврийн товчоо хүртэлх 400мм, 600мм-ийн голчтой 1.3 километр дулааны шугамыг 700мм болгон өргөтгөнө.

Дулаан дамжуулах гол шугам шинээр барьснаар төвлөрсөн дулаан хангамжийн үйлчлэх хүрээ нэмэгдэж, дулааны үйлчилгээний чанар хүртээмж дээшилнэ.


Хяналт, удирдлагын SCADA систем, ухаалаг тоолуур суурилуулснаар дулааны сүлжээний хяналт, мэдээлэл сайжирна.

ЭДИЙН ЗАСГАА СЭРГЭЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

//

Дулааны III цахилгаан станцаас хотын төвийг дулаанаар хангадаг дулаан дамжуулах гол шугамын ашиглалтын хугацаа дуусч эрсдэл өндөртэй болсон бөгөөд энэхүү шугамыг өргөтгөн шинэчилснээр хотын дулаан хангамжийн найдвартай ажиллагаа дахин 35 жилээр уртсах төдийгүй Дулааны III цахилгаан станцын хүчин чадал нэмэгдэх үед дамжуулах дулааны эрчим хүчний хүртээмж дээшилнэ.

//







**АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ
ДЭЭШЛҮҮЛЖ, ДУНДАЖ
ДАВХАРГЫГ ДЭМЖИХ
ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦООГ
БИЙ БОЛГОХ ЗОРИЛТ**



АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ
ДЭЭШЛҮҮЛЖ, ДУНДАЖ
ДАВХАРГЫГ ДЭМЖИХ
ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦООГ БИЙ
БОЛГОХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД



ХУРИМТЛАЛЫН НЭГДСЭН САНГИЙН ХУУЛИЙН ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛЖ БАЙНА

Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн 2020 оны 11 сарын мэдээллээр Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын 15-аас дээш насны иргэдийн 49.9 хувь буюу 434.7 мянган хүн хашаа, байшин гэрт амьдарч байна.



Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд “Хуримтлалын нэгдсэн сангаар дамжуулж, иргэн бүрийн боловсрол, эрүүл мэнд, тэтгэвэр, орон сууц, нийгмийн хамгааллын үйлчилгээг цогцоор нь шийдвэрлэх тогтолцоонд үе шаттайгаар шилжих” гэсэн зорилтыг дэвшүүлсэн. Энэ ажлын хүрээнд Хуримтлалын нэгдсэн сангийн тухай хуулийн төсөл боловсруулж байна.

Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зохистой удирдлагыг төлөвшүүлж, санг алдагдалгүй түвшинд хүргэх, нийгмийн даатгалын бүрэн бие даасан тогтолцоог бий болгох цаашлаад тэтгэврийн нөөц санг ашигт малтмалын орд газрын өгөөж болон ипотекийн санхүүжилтийн эх үүсвэрээс бүрдүүлдэг болох зорилттой байна. Мөн хуримтлалын нэгдсэн сангаар дамжуулж, иргэн бүрийн боловсрол, эрүүл мэнд, тэтгэвэр, орон сууц, нийгмийн хамгааллын үйлчилгээг цогцоор нь шийдвэрлэх тогтолцоонд шилжинэ.



ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САН БАЙГУУЛАХ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛЖ ЭХЭЛЛЭЭ



Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлж, уул уурхайгаас олох үр шимийг баялгийн сангаар дамжуулан иргэн бүрд тэгш, шударга хүртээх тогтолцоог бүрдүүлэх зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Үндэсний баялгийн санг байгуулах ажлыг эхлүүллээ.

Ерөнхий сайдын 2021 оны 4 дүгээр сарын 13–ны өдрийн 89 дүгээр захирамжаар Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Уул Уурхай, Хүнд Үйлдвэрийн Сайдаар ахлуулан байгууллаа.

Тус ажлын хэсэг нь Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулж, 2021 оны 5 дугаар сард Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр ажиллаж байна.

АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ
ДЭЭШЛҮҮЛЖ, ДУНДАЖ
ДАВХАРГЫГ ДЭМЖИХ
ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦООГ БИЙ
БОЛГОХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

Байгалийн баялгийн үнэлгээ

ГЕОЛОГИ, ХАЙГУУЛ
Эрэл хайгуул

- ✓ Байгалийн баялаг
- ✓ Геологийн хайгуул
- ✓ Эрдсийн нөөц

Технологийн шинэчлэл, зардал бууруулах

ОЛБОРЛОЛТ
Зогсох эрхгүй уурхай

- ✓ Үйлдвэрийн шинэчлэл
- ✓ 1072
- ✓ Ахмадын зээл
- ✓ Цахилгаан, дулаан
- ✓ Шахмал түлш
- ✓ 300,000 төгрөг



Гүн боловсруулалт, нэмүү өртөг, ажлын байр

БОЛОВСРУУЛАЛТ
Боловсруулах үйлдвэр

- ✓ Нүүрс баяжуулах үйлдвэр
- ✓ Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр
- ✓ Газрын тос боловсруулах үйлдвэр
- ✓ Гангийн үйлдвэр

Эрдэс баялгийн бирж

БОРЛУУЛАЛТ
Бүтээгдэхүүн

- ✓ Дэлхийн зах зээлийн үнэ
- ✓ Шударга, тэгш өрсөлдөөн
- ✓ Ил тод, нээлттэй арилжаа

Үндэсний баялгийн сан

ХУВААРИЛАЛТ
Сангууд

- ✓ Тогтворжуулалтын сан
- ✓ Ирээдүйн өв сан
- ✓ Хөгжлийн сан

“ Байгалийн баялгаас олсон орлогоос сан бүрдүүлж, санхүүгийн үр ашигтай мега төслүүдэд хөрөнгө оруулалт хийх, уул уурхайгаас бусад эдийн засгийн салбарыг дэмжиж, эдийн засгийг чадавхыг сайжруулан, иргэдийн орлогыг нэмэгдүүлж, ногдол ашиг хүртээнэ. “




ХАЛАМЖААС ХӨДӨЛМӨРТ ШИЛЖИХ ТОГТОЛЦООНЫ ӨӨРЧЛӨЛТҮҮДИЙГ ЭХЛҮҮЛЭВ

АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ
ДЭЭШЛҮҮЛЖ, ДУНДАЖ
ДАВХАРГЫГ ДЭМЖИХ
ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦООГ БИЙ
БОЛГОХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

//

Халамжийн хамрах хүрээг оновчтой болгож, зорилтот бүлэгт чиглүүлэх, үүний зэрэгцээгээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг хэрэгжүүлснээр хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрт байдлыг хадгалж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулж, чинээлэг дундаж давхаргыг нэмэгдүүлнэ.

//



2021 → 5,000

ЗАЛУУСЫГ ХӨДӨЛМӨРТ БЭЛТГЭНЭ

Нийгмийн халамжийн хамрах хүрээг тэлж, хамрагдах хүний тоо нэмэгдсээр байгаа боловч ажилгүйдэл, ядуурал буурахгүй байна. Халамжид зарцуулж байгаа нийт хөрөнгийн дөнгөж 30 гаруй хувь нь халамж зайлшгүй шаардлагатай, орлого багатай нийгмийн эмзэг бүлэгт очиж байгаа нь нийгмийн халамжийн хамрах хүрээг оновчтой болгож зорилтот бүлэгт чиглүүлэх шаардлагатай байгааг харуулж байна. Иймд халамжийн бодлогыг эргэн харах, халамжийн хөтөлбөр бүрийн нөлөөллийн үнэлгээг хийх, хөдөлмөр эрхлэлтийн бодлоготой уялдуулж, “Халамжаас–хөдөлмөрт” шилжих хөтөлбөрийг цогц байдлаар хэрэгжүүлж эхэллээ.

Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг удирдах болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, зохицуулалтын шийдвэр гаргахад шинжлэх ухааны үндэслэл, тооцоо, судалгаатай байх боломжийг хангахад зориулагдсан “Хөдөлмөр эрхлэлтийн системийн динамик загвар”-ын ерөнхий схем, секторуудыг боловсруулаад байна.

2021 онд нийт 20.5 тэрбум төгрөгийг хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр, цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөсөн.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, хувь хүний цогц сургалтын хөтөлбөр боловсруулан, жил бүр 5,000 залуучуудыг хамруулж хөдөлмөрт бэлтгэх, ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлэх төслийг баталлаа.



ЗАЛУУС ХОРООЛЛЫГ БАРИХ АЖЛЫГ ЭХЛҮҮЛЛЭЭ

Залуус 1 орон сууцны хорооллыг Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, шинэ суурьшлын бүсийг хөгжүүлэх, иргэдийг орлогод нийцсэн орон сууцаар хангах хүрээнд Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 57 га талбайд байгуулахаар төлөвлөж байна. Орон сууцны хороолол нь эрчим хүчний хэмнэлттэй 5,000–6,000 айлын орон сууц, нийгмийн дэд бүтцийн барилга, байгууламж, үйлчилгээний байгууламж, спорт цогцолбор, мэдээлэл технологийн парк, төрийн зарим нэг байгууллагын барилга гэх мэт амьдрах орчин, ажлын байрны цогц төлөвлөлттэй байна. Хорооллын бүтээн байгуулалтыг 2022 оноос эхлэн үе шаттайгаар хийх бөгөөд 2024 онд эхний ээлжийн орон сууцны хорооллыг ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

Залуус 1 хороололд шаардлагатай гадна инженерийн дэд бүтцийн шугам сүлжээний төлөвлөлтийн шийдэл, хөрөнгө оруулалтын тооцоог шинэчиллээ. Залуус 1, 2 хорооллын дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний ажлын зургийн даалгавар, дулааны эх үүсвэрийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах даалгаврын төслийг боловсруулан холбогдох байгууллагуудаас санал авч, “Залуус” хорооллын техник, эдийн засгийн үндэслэлийг гүйцэтгэгчийг сонгон шалгарууллаа.

Хорооллын техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа, эх загвар зураг, гадна инженерийн шугам, сүлжээний болон ажлын зураг төсөл боловсруулах ажил хийгдэж байгаа ба 2021 онд хорооллын зураг төслийн ажлыг бүрэн дуусгаж, 2022 оноос эхлэн хорооллын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ.



**АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ
ДЭЭШЛҮҮЛЖ, ДУНДАЖ
ДАВХАРГЫГ ДЭМЖИХ
ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦООГ БИЙ
БОЛГОХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД**

“ЗАЛУУС” ХОРООЛОЛ



Залуус 1, 2, 3 хороолол баригдсанаар зорилтот бүлгийн 20,000 орчим өрх орон сууцтай болно. Агаар, хөрсний бохирдол зохих хэмжээгээр буурах, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөл бүрдэнэ. Үйлчилгээний газрууд, нийгмийн дэд бүтэц, их дээд сургуулийн хотхон, мэдээллийн технологи, IT төв, төрийн зарим чиг үүргийн байгууллага зэргийг хороололд цогцоор нь байгуулснаар 3,000 орчим ажлын байр шинээр бий болно.





АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ
ДЭЭШЛҮҮЛЖ, ДУНДАЖ
ДАВХАРГЫГ ДЭМЖИХ
ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦООГ БИЙ
БОЛГОХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

“ Төлөвлөгөө хэрэгжсэнээр иргэд орон сууцтай болох, эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөл бүрдэхээс гадна барилгын салбарын хөрөнгө оруулалт, эдийн засгийн идэвхжил нэмэгдэх үр ашигтай. ”

ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙН ХӨТӨЛБӨРИЙГ ЭРЧИМЖҮҮЛЛЭЭ


Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөөний 2.3-т “Ипотекийн жилийн 6 хувийн хүүтэй зээлийн эх үүсвэрийг мөнгөний бодлогын зорилтод нийцүүлэн нэмэгдүүлж, барилгын салбар, түүнийг дагалдах салбарыг идэвхжүүлэхэд чиглүүлэх талаар төв банктай хамтран ажиллах” гэж заасны дагуу ипотекийн зээлийн хүртээмжийг 2021–2024 он хүртэл нэмэгдүүлэхэд нийт 2.0 их наяд төгрөг зарцуулахаар төлөвлөсөн.

Арилжааны банкуудаар дамжуулан 2021 оны 4 дүгээр сарын 28-ны байдлаар 230.9 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг 3,138 зээлдэгчид олгоод байна. Үүнээс 78.3 хувь буюу 180.9 тэрбум төгрөгийн 2,209 зээлийг Улаанбаатар хотод, 21.7 хувь буюу 50 тэрбум төгрөгийн 929 зээлийг орон нутагт олгосон байна.



ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙН САНХҮҮЖИЛТ


/2021.05.05–ны байдлаар/



ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫГ САЙЖРУУЛАХ АЖЛЫГ ЭХЛҮҮЛЛЭЭ

Салбар дундын болон сүлжээ лабораториудын үйл ажиллагааг зохицуулан шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлд нийцүүлэхээр ажиллаж байна.

ТӨРӨЛЖСӨН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ



АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ
ДЭЭШЛҮҮЛЖ, ДУНДАЖ
ДАВХАРГЫГ ДЭМЖИХ
ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦООГ БИЙ
БОЛГОХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

//

Лабораториудын нэгдсэн мэдээллийн сан үүсгэж тоног төхөөрөмжийн бүртгэлийг хөтлөн, салбар дундын болон сүлжээ лабораториудад хэрэгжих судалгааны төслүүдийг санхүүжүүлэх, гарсан үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх зохицуулалт бий болгоно. Эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн суурь санхүүжилтийг шийдвэрлэж үр дүнд суурилсан тогтолцоог нэвтрүүлнэ.

//



АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ
ДЭЭШЛҮҮЛЖ, ДУНДАЖ
ДАВХАРГЫГ ДЭМЖИХ
ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦООГ БИЙ
БОЛГОХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД



БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ

Боловсролын ерөнхий хуулийн төсөл болон дагалдах хуулийн төслийг УИХ-д өргөн барих бэлтгэл ажил бүрэн хангагдлаа.

Хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн боловсролын
ЗОРИЛГО, ЗОРИЛТ

СУРГАХААС СУРАЛЦАХУЙ РУУ

чиглэсэн дэлхий нийтийн хандлагын өөрчлөлт

БОЛОВСРОЛЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО (оновчтой,
улс төрөөс хараат бус, мерит зарчимд суурилсан)

Боловсролын цахим шилжилт
ЦАХИМ БОЛОВСРОЛ, ЗАЙНЫ СУРГАЛТ

Боловсролын чанар, үр дүн, гүйцэтгэлд суурилсан
САНХҮҮЖИЛТ

//

- ✓ Боловсролын түвшин, шатлал, түвшин хоорондын шилжилтийг тодорхой, ойлгомжтой болгоно;
- ✓ Чадамжид суурилсан тогтолцоонд шилжинэ;
- ✓ Насан туршийн суралцахуйд суурилсан тогтолцоог хөгжүүлнэ;
- ✓ Багшийн үнэлгээ, урамшуулал, тасралтгүй хөгжлийн цогц системийг бий болгоно;
- ✓ Дээд боловсролын чанарын баталгаажуулалтын иж бүрэн тогтолцоог бий болгоно;
- ✓ Үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бий болгоно;
- ✓ Улсын хөгжлийн бодлого, мерит тогтолцоо хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулж, оролцогч талуудын тэгш байдлыг хангана.

//


- ➔ Төрт ёс, түүх, соёл, уламжлал, үнэт зүйлсийг өвлөсөн, ардчилсан, хүмүүнлэг, ёс зүйг дээдлэн сахисан, дэлхийд өрсөлдөхүйц мэдлэг, чадвартай, нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулдаг, эрүүл, хариуцлагатай иргэнийг хөгжүүлэхэд боловсрол чиглэнэ;
- ➔ Боловсролын агуулгыг суралцагчийн нас, хөгжлийн онцлог, авьяас, сонирхол, хувийн болон нийгмийн хэрэгцээ, үндэсний өв уламжлал, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн хандлага, мэргэшлийн үндэсний шаталсан бүтэцтэй нийцүүлэн сургалтын хөтөлбөрөөр хэрэгжүүлнэ;
- ➔ Дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага, боловсрол дахь цахим шилжилт, иргэнд боловсрол эзэмших тэгш, хүртээмжтэй боломжийг олгох цахим, зайны сургалттай холбоотой зохицуулалтыг боловсролын хууль тогтоомжид анх удаа тусгасан. Бүх шатны сургалтын агуулга, хөтөлбөрийг цахим хэлбэрт шилжүүлнэ;
- ➔ Монгол Улсад судалгааны их сургууль байгуулах, олон улсад өрсөлдөх хэмжээнд хөгжүүлэх зорилгоор улс орны эдийн засаг, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд манлайлах, шинжлэх ухаан, технологи, инновацын тэргүүлэх чиглэлийг хөгжүүлэх, шилдэг хүний нөөцийг бэлтгэх, шинэ мэдлэг, технологи бүтээх, эдийн засгийн эргэлтэд оруулах, олон улсад өрсөлдөх судалгаа, эрдэм шинжилгээ, сургалт, үйлдвэрлэлийг хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ;

Боловсролын санхүүжилтийг боловсролын зорилго, стандартын хэрэгжилтийг хангах суурь нөхцөлийг бүрдүүлж, боловсролын үйлчилгээний гүйцэтгэл, чанар, үр дүнд чиглэдэг болгоно.

ТӨРИЙН ӨМЧИТ 6 ИХ СУРГУУЛИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААГ ЭХЛҮҮЛЛЭЭ

МУИС, АШУУИС, ШУТИС, ХААИС, МУБИС, СУИС–иуд Монгол Улсын дээд боловсролын салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, эрдэм шинжилгээ, сургалт, үйлдвэрлэлийн нэгдлийг хангахад тэргүүлэх үүрэг гүйцэтгэж ажиллах хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурлаа.

Энэ хүрээнд төрийн өмчийн тэргүүлэх их сургуулиуд:



Шинжлэх ухаан, дээд боловсролын салбарын хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтарсан судалгааг өргөжүүлэх, бий болгоход онцгой анхаарч ажиллах үүргийг энэхүү санамж бичгээр хүлээн ажиллаж байна.



АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ ДЭЭШЛҮҮЛЖ, ДУНДАЖ ДАВХАРГЫГ ДЭМЖИХ ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦООГ БИЙ БОЛГОХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

“ Санамж бичгийн хүрээнд 38 ажил хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 2020–2021 оны хичээлийн жилд 12 ажлыг төлөвлөөд байна. Эдгээр 12 ажлын хүрээнд 6 сургуулийн 102 багш, судлаачдаас бүрдсэн 12 баг хамтран ажиллаж байна. ”





ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНИЙ НЭЭЛТТЭЙ ЦАХИМ СУРГАЛТЫН СИСТЕМИЙГ ХӨГЖҮҮЛЛЭЭ

www.econtent.edu.mn

АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ
ДЭЭШЛҮҮЛЖ, ДУНДАЖ
ДАВХАРГЫГ ДЭМЖИХ
ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦООГ БИЙ
БОЛГОХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

Боловсрол, шинжлэх ухааны яамнаас ерөнхий боловсролын сургуульд ашиглагдаж буй сурах бичгийн цахим хувилбар болон сургалтын хөтөлбөрийн дагуу боловсруулагдсан цахим контент байршуулах зорилготой “Е-контент систем”-д сурах бичиг, интерактив, видео хичээл, теле хичээл гэсэн ангиллаар 3,900 гаруй контентыг байршуулсан байна.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй үүрэн холбооны үйлчилгээ үзүүлэгч бүх оператор компанийн сүлжээний дата, ухаалаг төхөөрөмж ашиглан дээрх цахим контентыг үнэ төлбөргүй үзэх боломжийг бүрдүүлсэн.

Мөн Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Монгол Улсад Ковид-19 цар тахлыг хязгаарлах, үүнээс гарах сөрөг нөлөөг бууруулахад нэн шаардлагатай нийгмийн үйлчилгээний чадавхыг бэхжүүлэх нь” хамтарсан төслийн хүрээнд боловсролын салбарын суурь үйлчилгээг дэмжих чиглэлээр цахим сургалтын платформыг боловсруулах, сурах бичгийг цахим хэлбэрт шилжүүлэх ажил хийгдэж байгаа бөгөөд сургалтад зориулсан 104 интерактив, цахим контентыг Казак, Тува, дохионы хэлний хувилбартай бэлтгэж нийтийн хүртээл болгоод байна. Түүнчлэн интернэт ашиглах боломжгүй байгаа хүүхдүүдэд зориулж 30 аудио контент бэлтгэж байна.


econtent.edu.mn систем дээр байршсан контентын тоо

№	Ангилал	Сурах бичиг	Теле хичээл	Интерактив контент
1	Сургуулийн өмнөх боловсрол		324	20
2	Бага, дунд боловсрол	180	2,825	84
3	Элсэлтийн ерөнхий шалгалт		151	
4	Тусгай хэрэгцээт боловсрол		149	
5	Насан туршийн боловсрол		127	
Нийт		180	3,576	104

//

“Эцэг, эхийн систем”-ийн
мобайл аппликэйшнийг
164,300 хэрэглэгч татаж
авсан байна.

//



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР ДАХЬ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ ӨРНӨЖ БАЙНА

Хүн амыг өвчилсөн хойно нь бус өвдөхөөс өмнө нь урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Өвөрхангай, Ховд аймаг дахь Бүсийн оношилгоо, эмчилгээний төв болон Улаанбаатар хотын Хан-Уул, Сонгинохайрхан, Багануур дүүрэгт “Эрүүл мэндийг дэмжих төв” – үүдийг ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

Өвөрхангай, Ховд аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Хан-Уул дүүргийн “Эрүүл мэндийг дэмжих төв” байгуулан эрт илрүүлэг, үзлэг шинжилгээнд зориулж 20 гаруй төрлийн иж бүрэн тоног төхөөрөмжийг дагалдах хэрэгслийн хамт суурилууллаа.

Түлэнхийн төвийн барилга угсралтын ажил 95 хувийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд энэ оны II улиралд багтаан ашиглалтад оруулна.

Зүрх судасны төв, Хавдар судлалын үндэсний төвийн II салбар, Эрхтэн шилжүүлэн суулгах үндэсний төвийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, зураг төсөл нь бэлэн боллоо.

Нас баралтын тэргүүлэх шалтгаан



ЗҮРХ СУДАС



ХАВДАР



ОСОЛ
ГЭМТЭЛ



ХООЛ
БОЛОВСРУУЛАХ
ӨВЧИН



АМЬСГАЛЫН
ЗАМЫН ӨВЧИН

АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ
ДЭЭШЛҮҮЛЖ, ДУНДАЖ
ДАВХАРГЫГ ДЭМЖИХ
ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦООГ БИЙ
БОЛГОХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

“ Иргэдийг 2 жил тутамд урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамрагддаг болгох тогтолцоог бүрдүүлж, өвчлөлийг эрт илрүүлж, эмчилгээ, сувилгааны чанар, хүртээмжийг сайжруулж, цаг бус нас баралтыг бууруулж, хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлнэ. “



Халдварт бус өвчний шалтгаант нас баралт

Хүн амын нас баралтын дотор

70%



АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ
ДЭЭШЛҮҮЛЖ, ДУНДАЖ
ДАВХАРГЫГ ДЭМЖИХ
ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦООГ БИЙ
БОЛГОХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД



ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫГ ГҮЙЦЭТГЭЛЭЭР САНХҮҮЖҮҮЛЖ ЭХЭЛЛЭЭ

Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг “Нэг худалдан авагчийн тогтолцоо” буюу улсын төсвийн санхүүжилт болон эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийг эрүүл мэндийн даатгалын байгууллага нэгдсэн байдлаар зохицуулж, эрүүл мэндийн байгууллагаас иргэдэд үзүүлсэн тусламж үйлчилгээний гүйцэтгэлээр санхүүжилт олгох тогтолцоог нэвтрүүлж байна.

2021 оноос эхлэн Улсын болон хувийн эмнэлгүүд үзүүлсэн чанартай тусламж, үйлчилгээнийхээ тоогоор Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас тогтоосон тарифын дагуу санхүүжилтээ авч эхэлсэн. Нийт 2,472 эрүүл мэндийн байгууллагатай гэрээ байгуулан гүйцэтгэлийн санхүүжилтийг эрүүл мэндийн даатгалын сангаас олгоод байна.

Өндөр өртөгтэй тусламж үйлчилгээний зардлыг бүхэлд нь оношийн хамааралтай бүлгийн зардалд шингээж, өртгийг тооцон эрүүл мэндийн байгууллагуудад гүйцэтгэлээр олгож эхэллээ.

Эрүүл мэндийн байгууллагуудад гүйцэтгэлийн санхүүжилт нэвтэрснээр эрүүл мэндийн чанартай, тусламж, үйлчилгээг даатгуулагчид үзүүлж, улсын болон хувийн хэвшлийн эмнэлгийн хооронд шударга өрсөлдөөн бий болохын зэрэгцээ иргэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахдаа төлөх төлбөрийн хэмжээ буурч, эрүүл мэндийнхээ улмаас санхүүгийн дарамтад орох асуудлыг бууруулах ач холбогдолтой. Эрүүл мэндийн байгууллагууд үзүүлсэн тусламж, үйлчилгээнийхээ тоо, чанарын гүйцэтгэлд тулгуурлан санхүүжилтээ авдаг болно.



Эрүүл мэндийн байгууллагуудад хүн амд үзүүлсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлд тулгуурлан эхний 4 сарын байдлаар нийт 242.8 тэрбум төгрөг олгов.



ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ОРОЛЦОО

УИХ-аар хэлэлцэж буй Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хөдөлмөр эрхлэлтийн уян хатан нөхцөлийг дэмжих хэд хэдэн заалтууд тусгагдсаны дотор зайнаас ажиллах үеийн зохицуулалт, дадлагажигч, бүтэн бус цагийн гэрээт ажилтан, хавсран гүйцэтгэх болон зэрэгцээ ажлын гэрээний талаарх ойлголтуудыг нарийвчлан тусгаад байна. Ийнхүү хөдөлмөр эрхлэлтийн уян хатан нөхцөлийг дэмжсэн хуулийн заалтуудыг баталснаар албан бус эдийн засагт ажиллагчид нийгмийн хамгааллын тогтолцооны гадна үлддэг байдал буурч, ялангуяа эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн зах зээлд оролцох боломж нь нэмэгдэх юм.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамруулах, чадавхжуулах, өрхийн бизнес эрхлэхэд барьцаагүй, хүүгүй санхүүгийн дэмжлэг олгох зэрэг тусгайлсан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг. Тухайлбал, хүн амын бүлгүүдийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн 6 хөтөлбөрийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2019–2020 онуудад хэрэгжүүлсэн бөгөөд нийт 29,360 иргэн хамрагдсан тэдгээрийн 54.8 хувь буюу 16,102 нь эмэгтэйчүүд хамрагдсан байна. Гэсэн хэдий ч нэг эмэгтэй хүнд ногдох санхүүжилтийн хэмжээ эрэгтэйчүүдийнхээс 15.1 хувиар бага буюу эмэгтэйчүүд хямд өртөгтэй арга хэмжээнд оролцдог гэсэн судалгааны дүн гарсан байна.

Иймд эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр нийт хөтөлбөрт хамрагдах иргэдийн тоог нэмэгдүүлэх, чанарт анхаарах хэрэгцээг тодорхойлон тэдгээрийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2021–2022 онд хэрэгжүүлэх 5 хөтөлбөрийг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоолоор энэ оны 2 дугаар сарын 9-ний өдөр баталсан ба улсын хэмжээнд хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Уг хөтөлбөрүүдэд 44,779 иргэнийг хамруулан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 20.5 тэрбум төгрөгийг зарцуулахаар төсөвлөсөн.

Хувиараа хөдөлмөр эрхлэгч болон бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид 1000 гаруй иргэн, ААН-д 2021–2023 оны хугацаанд 20 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгох ба зээлд хамрагдагчдын 50 хувьд эмэгтэй хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг хамруулахаар зорин ажиллаж байна.

“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төслийн хүрээнд 2020 оны 11 дүгээр сараас эхлэн Улаанбаатар хотын хувиараа хөдөлмөр эрхлэгч, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жижиг зээлийг Хаан болон Төрийн банкаар дамжуулан олгож эхэлсэн.

Өнөөдрийн байдлаар нийт 9 дүүргийн гэрээ байгуулсан ХААН, Төрийн банкны салбаруудаар дамжуулан 114 иргэнд 1 тэрбум төгрөгийн зээлийг олгоод байна. Зээлд хамрагдсан иргэдийн 51 хувь эмэгтэйчүүд байна.



**АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ
ДЭЭШЛҮҮЛЖ, ДУНДАЖ
ДАВХАРГЫГ ДЭМЖИХ
ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦООГ БИЙ
БОЛГОХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД**


“

- ✓ *Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшинг 50 хувьд хүргэнэ;*
- ✓ *Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүгийн дэмжлэгт хамрагдах эмэгтэйчүүдийн тоог 10 хувиар нэмэгдүүлнэ;*
- ✓ *Дэлхийн банкны Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн хүрээнд 500 орчим эмэгтэй хувиараа хөдөлмөр эрхлэгчид 5 орчим тэрбум төгрөгийн жижиг зээл олгоно;*
- ✓ *Уян хатан, зайнаас, цахимаар ажиллах эрх зүйн орчин бүрдүүлнэ;*

”

 **2021-2023** → **60%**
тэрбум

зээлд хамрагдагчдын





ХҮҮХДИЙН МӨНГИЙГ НЭМЭГДҮҮЛЭН ОЛГОЖ БАЙНА

АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ
ДЭЭШЛҮҮЛЖ, ДУНДАЖ
ДАВХАРГЫГ ДЭМЖИХ
ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦООГ БИЙ
БОЛГОХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

Коронавируст халдварын цар тахлын үед хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа шаардлагатай иргэдийн нийгмийн хамгааллыг сайжруулах, орлогыг нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 248 дугаар тогтоолоор хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 0–18 хүртэлх насны хүүхэд бүрд 2021 оны 1 дүгээр сарын 1-нээс өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 1 хүртэлх хугацаанд сар бүр 100 мянган төгрөгөөр үргэлжлүүлэн олгохоор шийдвэрлэсэн.

2021 онд хүүхдийн мөнгөн тэтгэмжид нийт 864 тэрбум төгрөгийг улсын төсөвт тусган батлуулсан. 2021 оны эхний 3 сарын байдлаар хүүхдийн мөнгөн тэтгэмжид 1.2 сая хүүхэд 360.6 тэрбум төгрөг олгоод байна.


//

Хүүхдийн мөнгийг нэмэгдүүлэн олгосноор өрхийн амьжиргааг дэмжиж, хүүхдэд шаардлагатай хүнс тэжээл худалдан авах боломжийг нэмэгдүүлэх, хөл хорионы үед хүүхдийн хөгжлийг хангах нөхцөл бүрдүүлнэ.

//



1,2 сая



ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ САНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ БАТЛУУЛЛАА



1 972 оны 30 дугаар тогтоолоор байгуулагдсан Хүүхдийн төлөө фондын санхүүжилтээр 68 цэцэрлэг, 10 гаруй эмнэлэг, пионерийн 70 гаруй зуслан, Хуримын ордон, Монголын Хүүхдийн ордон зэрэг нийт 200 гаруй бүтээн байгуулалт бий болгож, хүүхдийн эрх, хөгжлийг дэмжихэд үнэтэй хувь нэмэр оруулсан байдаг. Ийнхүү Монгол Улсын төр засаг, ард иргэдээс хүүхдийн сайн сайхны төлөө санаачилга гаргаж, асуудлыг шийдвэрлэж ирсэн түүхтэй бөгөөд энэхүү үйл хэргийг уламжлал болгон хэрэгжүүлж, УИХ-ын чуулганы хуралдаанаар Хүүхдийн төлөө сангийн тухай хуулийг эцэслэн хэлэлцэж, 2021 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр баталлаа.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд Хүүхдийн төлөө сангийн хүүхдийн төлөө бүтээн байгуулалт, хүүхдийн хөгжлийг дэмжих зорилгыг тодорхойлж, сангийн хөрөнгийн эх үүсвэрийг авто тээврийн сонирхол татахуйц улсын дугаарын үнэ хаялцуулах дуудлага худалдаанаас олсон орлого, гадаад улс, олон улсын байгууллага, аж ахуйн нэгжээс хүүхдийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон хандив, тусламж, хувь хүн, хуулийн этгээдээс өргөсөн хандив, буцалтгүй тусламж болон хүүхдийн сайн сайхны төлөө зохион байгуулсан соёл, урлагийн тоглолт, спортын арга хэмжээний орлого, хандиваас бүрдүүлэхээр тодорхойлсон.



1.2 САЯ
ХҮҮХЭД



АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ
ДЭЭШЛҮҮЛЖ, ДУНДАЖ
ДАВХАРГЫГ ДЭМЖИХ
ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦООГ БИЙ
БОЛГОХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

//

Хүүхэд, өсвөр үеийнхний хөгжил, оролцоог дэмжих нь тэднийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалахад чухал алхам болох тул Хүүхдийн төлөө сан байгуулах, улмаар сангийн хөрөнгийг хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтыг дэмжих, тив дэлхийн соёл, урлаг, спортын уралдаан, тэмцээнд амжилт гаргасан хүүхдийг урамшуулахад зарцуулдаг байх эрх зүйн орчныг бий болголоо. Хүүхдийн төлөө сан бий болсноор “НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны Хүүхдийн эрх ба бизнесийн зарчим”-ын хэрэгжилтийг хангах, хүүхдийн хөгжих эрхийн төлөө иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас нийгмийн хариуцлагын хүрээнд өгсөн хандив, тусламжийн хөрөнгө нэгдсэн зохицуулалтаар хүүхдийн хөгжлийг дэмжсэн бүтээн байгуулалт, үйл ажиллагаанд олон нийтэд нээлттэй, хяналттай зарцуулагдах эрх зүйн орчин бүрдэнэ.


//

АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ
ДЭЭШЛҮҮЛЖ, ДУНДАЖ
ДАВХАРГЫГ ДЭМЖИХ
ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦООГ БИЙ
БОЛГОХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

//

Нийгмийн хамгаалал,
хөдөлмөрийн салбарыг
цахимжуулснаар үйлчилгээ
шуурхай, чирэгдэлгүй, ил тод
болно.

//



ХӨДӨЛМӨР НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ЦАХИМЖУУЛЛАА

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын бүх үйлчилгээг цахимжуулж, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран иргэдэд хүртээмжтэй, нээлттэй, шуурхай, үр дүнтэй төрийн үйлчилгээг үзүүлэх зорилт тавин ажиллаж байна.

1. **www.job.gov.mn** – 2021 оны 4 дүгээр сарын 1–ний өдрөөс эхлэн хөдөлмөр эрхлэлтийн цахим үйлчилгээг ажил хайгч иргэн, ажил олгогчид үзүүлж эхэллээ.
2. **etuslamj.mn** – цахим системээр гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх нийгмийн ажил, үйлчилгээний бүртгэл, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, зөвлөгөө өгөх үйлчилгээг үзүүлж эхэллээ.
3. **ehalamj.mn** – нийгмийн халамжийн 10 үйлчилгээг “Нийгмийн халамжийн нэгдсэн систем”, цахим хуудас, төрийн үйлчилгээний цахим машин “ТҮЦ” машин, ebarimt аппликэйшнийг ашиглан авах боломжийг бүрдүүлээд байна.
4. **ezuvshuurul.mn** – ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний нэгдсэн мэдээллийн санг төвлөрүүлэн, ажиллах хүч илгээх болон гадаадаас ажиллах хүч авах гэсэн цахим системийг тус тус байршууллаа.
5. **Цахим эмнэлэг** – Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын харьяа Сэргээн засах эмнэлэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн үйлчилгээг бүрэн цахимжууллаа.
6. **Нийгмийн даатгалын дэвтэр** – 2021 оны 1 дүгээр сарын 1–ний өдрөөс эхлэн Нийгмийн даатгалын дэвтэрт бичилт хийх, баталгаажуулах ажлыг бүрэн цахимжууллаа.
7. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын мэдээллийн нэгдсэн санг Эйбл удирдлагын нэгдсэн системд байршууллаа.
8. **Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх** дуудлагын нэгдсэн төв байгуулах ажлын хүрээнд хэл яриа, сонсголын бэрхшээлтэй иргэдийн асуулт, санал хүсэлтийг авах, шаардлагатай мэдээллийг дохионы орчуулагчийн тусламжтай хүргэх аппликэйшн, цахим хуудсыг боловсруулж байна.
9. **Нийгмийн ажилтнуудыг CRM системд холбож**, “Иргэн –360 – Нийгмийн ажилтан”-ны мэдээллийн системийг хөгжүүлэх ажил дуусч туршилт, суурилуулалтын ажлууд хийгдэж байна.
10. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт **BI системийг хэрэглээнд нэвтрүүлээ.**
11. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 13 үйлчилгээ **e-mongolia** цонхонд холбогдлоо.

ХАРААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ЗОРИУЛСАН БИЧВЭРИЙГ ЯРИАНД ХӨРВҮҮЛЭХ ПРОГРАММЫГ ХӨГЖҮҮЛЖ БАЙНА

Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж байгаа “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог дэмжих, үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн хүрээнд уг программыг 2021 онд багтаан хөгжүүлж, хэрэглэж эхлэхээр ажиллаж байна.

Уг программ хангамжийг хөгжүүлэх ажлын даалгаврыг боловсруулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар ажиллаж байна.

Энэ хүрээнд харааны бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, хэрэглэгчид хялбар хэрэглэгдэх боломжтой 45 мянган үг бүхий үгсийн сантай бичвэрийг ярианд хөрвүүлэх программ хангамжийг хөгжүүлнэ.



Энэ программ хангамж нь харааны бэрхшээлтэй иргэдийг Android, IOS системтэй гар утас, Windows, Linux үйлдлийн системтэй ажилладаг болон смарт төхөөрөмжүүд, түүнчлэн мэдээллийн болон үйлчилгээний туслах төхөөрөмж буюу АТМ, ТҮЦ машин, автобусны карт уншигч, нүүр болон хуруу танигч зэргийг саадгүй ашиглах, цахим хуудас болон цахим мэдээллийг хөрвүүлэх боломжийг олгох ач холбогдолтой.

АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ
ДЭЭШЛҮҮЛЖ, ДУНДАЖ
ДАВХАРГЫГ ДЭМЖИХ
ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦООГ БИЙ
БОЛГОХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

//

Монгол Улсын хэмжээнд 2020 оны жилийн эцсийн байдлаар 11.9 мянган харааны бэрхшээлтэй иргэн байгаа бөгөөд уг программ хангамжийг харааны бэрхшээлтэй хүн бүр ашиглан мэдээлэл авах, төрийн үйлчилгээнд хамрагдах боломж бүрдэнэ.

//



МУЗЕЙН ТУХАЙ ХУУЛИЙГ БАТЛУУЛЛАА

АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ
ДЭЭШЛҮҮЛЖ, ДУНДАЖ
ДАВХАРГЫГ ДЭМЖИХ
ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦООГ БИЙ
БОЛГОХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД



Монгол Улсын Их Хурлын чуулганы 2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар Музейн тухай хуулийг хэлэлцэн баталлаа.


Музейн тухай хуулиар хувийн хэвшлийн музей ажиллах боломжтой болж, цуглуулга бүрдүүлсэн олон тооны иргэд үйл ажиллагаагаа нээлттэй явуулах ба иргэдийн гар дээр байгаа соёлын өв, үнэт зүйлсээ ил гарган дэлгэн үзүүлэх, худалдах, солилцох эрх зүйн үндэс бүрдэж далд, хууль бус эргэлтийн хэмжээ буурах боломжтой болно. Түүнчлэн, ирээдүй хойч үе хүүхэд залуучууд үндэсний соёлын өвтэй танилцах өргөн боломж нээгдэж боловсролын агуулга, сургалтын хөтөлбөрт музейн үзмэрүүдийг ашиглан хүүхдүүдийн мэдлэг чадвар дээшилнэ. Тус хуулиар музейн ажилтны нийгмийн баталгааг хангаж, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн бөгөөд музейн болон соёлын өвийн аюулгүй байдал, хадгалж хамгаалах үйл ажиллагааны эрх зүйн үндэс тавигдаж хуулиар хамгаалагдлаа.

//

Хууль батлагдсанаар өмчийн олон хэлбэрийн музей байгуулагдаж, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлс болон соёлын үнэт зүйлсийг хадгалж хамгаалах, сурталчлах үйл ажиллагааны цар хүрээ, үйлчилгээний чанар хүртээмж сайжирч, музейн нийгэм, эдийн засгийн үр өгөөж нэмэгдэх боломж бүрдэж байна. Мөн Соёлын өвийг хамгаалах, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэхтэй холбоотой Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээрийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхэд чухал түлхэц болох юм.


//

2020 он



246,971

Музейн үзмэр



Музейгээс зохион байгуулсан үзэсгэлэнгийн тоо

■ 2020 ■ 2021 ■ 2022 ■ 2023 ■ 2024

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН БАРИЛГЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛЛАА



Нийслэлийн Хан-Уул дүүргийн 21 дүгээр хороонд 2014 онд шавыг тавьсан Соёлын өвийн үндэсний төвийн шинэ барилга угсралтын ажлыг эрчимжүүлж, холбогдох арга хэмжээг авч ажилласны үр дүнд 2021 оны 3 дугаар сарын 26-ны өдөр шинэ барилгыг ашиглалтад орууллаа.

Нийт 8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй соёлын өвийн үндэсний төвийн шинэ барилга нь 60х40 метрийн хэмжээтэй, зоорийн болон нэг, хоёрдугаар давхраас бүрдсэн, нийт 8,000 м.кв талбайтай, 130 гаруй өрөө тасалгаа, хамгаалалтын хашаа, орц, гарц бүхий машин зам, авто зогсоол, ногоон байгууламжтай бөгөөд цахилгаан, цэвэр бохир, халуун усны төвлөрсөн шугамд бүрэн холбогдсон томоохон бүтээн байгуулалт боллоо.

АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ ДЭЭШЛҮҮЛЖ, ДУНДАЖ ДАВХАРГЫГ ДЭМЖИХ ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦООГ БИЙ БОЛГОХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД



2020 он

7,659,621

Соёл, урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчдийн тоо



2020 он

276,077

Түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тоо



//

Соёлын өвийн үндэсний төвийн шинэ байр ашиглалтад орсноор соёлын өвийг сэргээн засварлах лаборатори, өрөөний талбайн хэмжээ 20 дахин, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хадгалах сан хөмрөгийн өрөө, талбайн хэмжээ 28 дахин, үйл ажиллагааны нийт талбайн хэмжээ 14 дахин нэмэгдэж байна.

//



АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ
ДЭЭШЛҮҮЛЖ, ДУНДАЖ
ДАВХАРГЫГ ДЭМЖИХ
ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦООГ БИЙ
БОЛГОХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

//

Дэлхий нийтийг хамарсан цар тахлын үед халдварт өвчний тархалтыг бууруулахад усны хэрэглээ чухал бөгөөд хүн амд төлбөрийн дарамтгүйгээр ус, ариун цэврийн асуудлаа шийдвэрлэх боломжийг олгож байна. Аж ахуйн нэгжүүдэд ажлын байраа хадгалах, үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахад нь дэмжлэг болж байна.

//

ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР, ХУРААМЖИЙГ ТӨР ХАРИУЦАЖ БАЙНА


Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 211 тоот тогтоолоор айл өрхийн болон зарим үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөрийг төрөөс хариуцах шийдвэр гаргасан.

2020 оны 12-р сарын 1-ний өдрөөс 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд нийт дүнгээр 474 тэрбум төгрөгийг төрөөс хариуцан төлсөн байна.

Ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээ эрхэлдэг байгууллагуудын хувьд энэ хугацаанд орлогоо бүрэн авч, өр авлагагүй ажилласнаар усны үйлчилгээг тасралтгүй чанартай үзүүлэх нөхцөл хангагдлаа.


ХӨНГӨЛӨЛТӨД ХАМРАГДСАН ХЭРЭГЛЭГЧИЙН ТОО

/мянган хэрэглэгчээр/



ТӨРӨӨС ХАРИУЦСАН ЦЭВЭР, БОХИР УСНЫ ТӨЛБӨР

/сая төгрөгөөр/




ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАРИЛГУУДЫГ НЭГ МАЯГИЙН ЗУРАГ ТӨСӨЛТЭЙ БОЛГОЛОО

Монгол Улсын 2020, 2021 оны төсвийн 23.9 тэрбум төгрөгийн санхүүжилтээр хэрэгжүүлэх Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 83 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан төсөл, арга хэмжээний хүрээнд захиалагчдаас зураг төсөл боловсруулах 314 саналыг хүлээн авсан.

Зураг төслийн даалгаврыг боловсруулж, батлуулах, зураг төсөл боловсруулах зөвлөхийг сонгон шалгаруулах, зураг төслийг холбогдох норм, дүрмийн шаардлагад нийцүүлэн боловсруулах, хянан баталгаажуулах арга хэмжээг зохион байгуулж ажиллалаа.

АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ
ДЭЭШЛҮҮЛЖ, ДУНДАЖ
ДАВХАРГЫГ ДЭМЖИХ
ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦООГ БИЙ
БОЛГОХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД



№	Зориулалт	Зураг төслийн тоо
1	Ерөнхий боловсролын дунд сургууль	2
2	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургууль, цэцэрлэг	2
3	Бага сургууль	1
4	Цэцэрлэг	3
5	Дотуур байр	2
6	Эмнэлгийн зориулалттай барилга	3
7	Соёлын төв	2
8	Номын сан	1
9	Лаборатори	1
10	Сумын төвийн хөгжлийн төсөл арга хэмжээнд зориулсан барилга	7
Нийт		24

//

Энэ хүрээнд ерөнхий боловсролын дунд сургуулийн барилга, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургууль, цэцэрлэг, бага сургууль, дотуур байр, эмнэлэг, соёлын төв, номын сан, лаборатори, сумын төвийн хөгжлийн төсөл арга хэмжээнд зориулсан нэг маягийн барилгын төслийг газар хөдлөлтийн 6, 7, 8, 9 баллд тооцон боловсруулж, дуусган, магадлал хийлгэж байна.

//



ТОМ ОВРЫН АВТОБУСАНД БАЙГАЛИЙН ХИЙ НЭВТРҮҮЛЭХ ТӨСӨЛ

АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ
ДЭЭШЛҮҮЛЖ, ДУНДАЖ
ДАВХАРГЫГ ДЭМЖИХ
ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦООГ БИЙ
БОЛГОХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

Нийслэлийн нийтийн тээврийн том оврын автобусанд байгалийн хий нэвтрүүлэх төсөл нь агаарын бохирдлыг бууруулах зорилгоор байгалийн хийг Монгол Улсад нэвтрүүлэх, хийн агуулах, түгээх станц барих, нийслэлийн нийтийн тээврийн түлшийг байгалийн хийгээр солих хэрэглэгчдийн хэрэгцээг тасралтгүй хангах үндсэн зорилготой. Төслийг хамтран хэрэгжүүлэхээр БНСУ-ын “Ужин Ар Ди Си” ХХК-тай “Улаанбаатар байгалийн хий” ХХК –ийг байгуулж, 2017 оны 12 сарын 30-ны өдрөөс үйл ажиллагаа эхэлсэн бөгөөд хувийн хэвшлийн зүгээс 28.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгээд байна.

Шингэрүүлсэн байгалийн хийн агуулах нь бүтээгдэхүүнийг хүлээн авч хадгалан, тээвэрлэлт хийхэд зориулагдсан автоцистернийг цэнэглэх зориулалт бүхий байгууламж юм. Автомашиныг хийгээр цэнэглэх станцыг нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлж буй аж ахуйн нэгжүүдийн байршлаас хамаарч хотын баруун, зүүн, төв гэсэн 3 бүсэд хуваан авч үзэж байна.

4,000 м³ багтаамжтай буюу өдөрт тус бүр 300 автобус цэнэглэх нөөцтэй, нэгэн зэрэг 3 автобус цэнэглэх хүчин чадалтай хий түгээх станц барьж байгуулсан ба 1,200 м³ багтаамжтай хийн агуулахын барилгын ажлын гүйцэтгэл 60 хувьтай байна.



“ Нийслэл хотын тээврийн хэрэгслээс ялгарч буй хорт утааг бууруулж, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлж, нийтийн зорчигч тээврийн түлшний зардал буурч, төсөвт ирэх ачааллыг бууруулна. “




УЛААНБААТАР ХОТЫН УС ХАНГАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Улаанбаатар хотын ус хангамжийг нэмэгдүүлэх хөтөлбөрийн хүрээнд 2021–2025 онд 2 төсөл хэрэгжинэ.

УЛААНБААТАР ХОТЫН УС ХАНГАМЖИЙН БАРУУН ЭХ ҮҮСВЭРИЙГ БАЙГУУЛАХ ТӨСӨЛ



ХАЯГДАЛ УСЫГ ДАХИН БОЛОВСРУУЛЖ, ЭРГҮҮЛЭН АШИГЛАХ ТӨСӨЛ



Улаанбаатар хотын ус хангамжийн баруун эх үүсвэр



Ус гүн цэвэршүүлэх байгууламж



Шинээр байгуулагдах төв цэвэрлэх байгууламжийн цэвэрлэгдсэн хаягдал усыг дахин боловсруулж, Дулааны III, IV цахилгаан станцын технологийн хэрэгцээнд ашиглана.



Уг хөтөлбөр нь АНУ-ын Мянганы сорилтын корпорацийн 350 сая ам.долларын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжих бөгөөд Монгол Улсын Засгийн газраас АНУ-ын Мянганы Сорилтын корпорацитай байгуулах компакт гэрээ 2021 оны 3 дугаар сарын 31-нд хүчин төгөлдөр болж, санхүүжилтийн эрх нээгдлээ.

АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ ДЭЭШЛҮҮЛЖ, ДУНДАЖ ДАВХАРГЫГ ДЭМЖИХ ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦООГ БИЙ БОЛГОХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

//

Улаанбаатар хотын ус хангамжийн баруун эх үүсвэр ашиглалтад орсноор Туул, Био, Жаргалтант тосгон, Сонгинохайрхан дүүргийн Тахилт, Баянголын амын хэрэглэгчдийг болон шинээр байгуулагдах Шинэ зуун мод, Майдар хотуудыг усаар хангах боломжтой болно.

Дулааны станцуудын технологийн хэрэгцээнд саарал ус нийлүүлэх нь газрын гүний усыг хэмнэх, цэнгэг усны нөөцийг хамгаалах ач холбогдолтой юм.

//



ус нийлүүлнэ



ус дахин боловсруулна



ХҮҮГИЙН ХӨНГӨЛӨЛТТЭЙ НОГООН ЗЭЭЛ ОЛГОХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ
ДЭЭШЛҮҮЛЖ, ДУНДАЖ
ДАВХАРГЫГ ДЭМЖИХ
ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦООГ БИЙ
БОЛГОХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

Хүүгийн хөнгөлөлтийн санхүүжилт



1.8 тэрбум төгрөг


420 АЖ АХУЙН НЭГЖ

“ Ногоон зээлд хамрагдаж гэр, байшингийн халаалтыг цахилгаанаар шийдвэрлэснээр гэр хорооллын нэг өрхийн гэрийн зуухнаас агаарт хаягдах 9.9 кг хүхэрлэг хий, 16.8 кг PM10 тоосонцор, байшингийн зуухнаас 16.6 кг хүхэрлэг хий, 43.9 кг PM10 тоосонцрыг бууруулж байна. ”

Агаар, орчны бохирдлыг бууруулах ажлын хүрээнд хүүгийн хөнгөлөлттэй ногоон зээл олгох ажлыг хувийн хэвшилтэй хамтран зохион байгууллаа. Ногоон зээлийн хүүгийн хөнгөлөлтийг санхүүжүүлэх ажлыг Хаан банк, Төрийн банк, Хас банктэй хамтран хэрэгжүүлж байна. Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд амьдарч байгаа иргэдэд байшингийн дулаалга, сайжруулсан зуух, эко ариун цэврийн байгууламж худалдан авахад болон аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагад хаягдал бохир ус цэвэрлэх байгууламж суурилуулах зэрэг нийт 20 гаруй бүтээгдэхүүнд зориулж жилийн 9 хүртэл хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээл олгож байна.

Иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд жилийн 8–9 хувийн хүүтэй ногоон зээлд хамрагдаж халаалт, дулаалга, эко ариун цэврийн байгууламж, хог хаягдал дахин боловсруулах, бохир ус цэвэрлэх тоног төхөөрөмж зэргийг худалдан авч суурилуулан тав тухтай орчныг бүрдүүлж, агаар, хөрсний бохирдлыг бууруулахад хувь нэмэр оруулж байна.

2021 оны байдлаар аялал жуулчлалыг хөгжүүлэх, агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр нийт 420 гаруй иргэн, аж ахуйн нэгж ногоон зээлд хамрагдаж, 1.8 тэрбум төгрөгийн хүүний хөнгөлөлтийг улсын төсвөөс санхүүжүүллээ.



НӨХӨН СЭРГЭЭЛТ НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭГ ЭХЛҮҮЛЛЭЭ

Монгол Улсын Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан тушаалаар хүрээлэн буй орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах “Нөхөн сэргээлт-2024” нэгдсэн арга хэмжээг зарлаж, Ажлын хэсэг байгуулж, арга хэмжээний төлөвлөгөөг баталлаа.

Аймаг, нийслэлийн Засаг дарга нарын мөрийн хөтөлбөрт нөхөн сэргээлтийг эрчимжүүлэх, орон нутгийн төсөвт суулган тодорхой газрын нөхөн сэргээлтийг хийлгүүлэх, аймаг, нийслэлд нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлж байна.

Олон жил нөхөн сэргээлт хийгээгүй орхисон ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн судалгааг гаргаж, Цагдаагийн ерөнхий газрын Экологийн цагдаагийн алба, Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт шилжүүлэн шалгуулж, тэдгээр тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагаар нөхөн сэргээлтийн ажлыг хийлгүүлэх арга хэмжээний бэлтгэл ажлыг хангаад байна.

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Ялбаг, Бугант тосгонд хууль бусаар ашигт малтмал олборлож эвдрэлд оруулсан 200 гаруй га талбайд хяналтын тооллого, хэмжилт хийж, буруутай этгээдээр нөхөн сэргээлт хийлгүүлэхээр ажиллаж байна.

Аймаг, нийслэлийн Засаг дарга нарын мөрийн хөтөлбөрт нөхөн сэргээлтийг эрчимжүүлэх, орон нутгийн төсөвт суулган тодорхой газрын нөхөн сэргээлтийг хийлгүүлэх чиглэл өгсний дагуу нийт 251 га талбайд нөхөн сэргээлт хийхээр тусгуулсан.

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагуудын 2021 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд эвдэрч олон жил орхигдсон 200 гаруй га талбайг нөхөн сэргээлт хийлгүүлэхээр ажиллаж байна.

АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ
ДЭЭШЛҮҮЛЖ, ДУНДАЖ
ДАВХАРГЫГ ДЭМЖИХ
ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦООГ БИЙ
БОЛГОХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

“

Уул уурхайн болон бичил уурхай, хууль бус ашигт малтмал олборлосны улмаас эвдрэлд орж, олон жил нөхөн сэргээлт хийгдээгүй талбайг нөхөн сэргээж, байгалийн тэнцвэрт байдлыг хадгална.

”

Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт 2020 онд хийсэн нөхөн сэргээлт



ӨМНӨ



ДАРАА

1 ЖИЛИЙН ДОТОР ЭРЧИМТЭЙ

 **e**mongolia
Цахим үндэстэн

ТА БҮҮНИЙ ОРЛОГОС ИМЖАЛ!





**ШУДАРГА ЁС,
ЦАХИМ ЗАСАГЛАЛЫГ
БЭХЖҮҮЛЭХ ЗОРИЛТ**





ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН СИСТЕМ

ШУДАРГА ЁС, ЦАХИМ
ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭХ
ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД



2021.05.10

Төрийн үйлчилгээний нэгдсэн
“Е-монголиа” системд

 **36** БАЙГУУЛЛАГА

 **516** ҮЙЛЧИЛГЭЭ

УИХ | **1**

ЕС-ын харьяа
байгууллага | **28** БХБЯ | **30**

ШС-ын харьяа
байгууллага | **53** БШУЯ | **5**

ЗГХЭГ-ын харьяа
байгууллага | **1** ЗТХЯ | **10**

БОАЖЯ | **1** ХХААХҮЯ | **77**

ГХЯ | **4** ЭХЯ | **10**

СЯ | **50** ЭМЯ | **1**

ХЗДХЯ | **129** ХХМТГ | **4**


ХНХЯ | **20** НИЙСЛЭЛ | **91**

Монгол Улсын Засгийн газраас төрийн үйлчилгээ, үйл ажиллагааг цахимжуулах, иргэд, хуулийн этгээдэд учирч байсан хүнд суртлыг халах, төрийн байгууллагуудын бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэхэд тулгарч байсан хүндрэл бэрхшээлийг мэдээллийн технологийн тусламжтай шийдвэрлэхэд чиглэсэн арга хэмжээний нэг нь “Төрийн үйлчилгээний нэгдсэн систем” – emongolia.mn хэрэгжүүлсэн явдал юм. Уг төслийн үр дүнд төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр өгөөж дээшилсний дээр иргэдийн сэтгэл ханамж эрс нэмэгдсэн үр дүн гарч байна.

2021 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн байдлаар нийт 36 байгууллагын 516 үйлчилгээг төрийн үйлчилгээний E-Mongolia цахим систем холбоод байна. Төрийн үйлчилгээний цахим систем 2020 оны 10 дугаар сарын 1-ний өдөр ашиглалтад орсноос хойш төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр авах иргэдийн тоо тогтмол өсөж байна.

Иргэд төрийн үйлчилгээний нэгдсэн E-Mongolia системээр 1,406,585 хэрэглэгч үйлчилгээг цахим хэлбэрээр авснаар төрийн байгууллага руу ирж, буцах зардалд 3.4 тэрбум төгрөг, үйлчилгээ авахад шаардагдах баримт бичиг бүрдүүлэх зардалд 497.8 сая төгрөг, үйлчилгээ авахдаа зарцуулж буй хугацаанаас үүдэлтэй зардалд 31.7 тэрбум төгрөг нийт 35.6 тэрбум төгрөг хэмнэсэн байна.

1,406,585 хэрэглэгчтэй болов | **286,500** иргэн **759,138** удаа гар утаснаасаа хандсан



Судалгаанаас харахад иргэд төрийн үйлчилгээ авахын тулд төрийн байгууллага руу дунджаар хэдэн удаа очих шаардлагатай талаар дүн шинжилгээ хийж үзэхэд:

1 удаа очих шаардлага гардаг үйчилгээ **46.5%**
 2 удаа очих шаардлага гардаг үйчилгээ **37.4%**
 3 ба түүнээс дээш удаа очих шаардлага гардаг үйчилгээ **16.1%**

Цахим үйлчилгээ
авснаар


Төрийн байгууллага руу
ирж, буцах зардалд
3,439,583,211 ₮


Шаардагдах баримт
бичиг бүрдүүлэх зардалд
497,806,856 ₮


Хугацаанаас үүдэлтэй
зардалд
31,691,374,227 ₮


ЦАХИМ ЭЛЧИН САЙДЫН ЯАМ БАЙГУУЛАХ АЖЛЫГ ЭХЛҮҮЛЛЭЭ

www.mongoliatradingportal.gov.mn

Худалдааг хөнгөвчлөх, худалдааны үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж, бусад шаардлагатай мэдээллийг багтаасан цахим хуудсыг 2020 оны 12 дугаар сарын 12-ны өдөр нээн, ашиглалтад оруулсан. Энэхүү мэдээллийн сан нь гадаад дотоодын бизнес эрхлэгчид Монгол Улсад экспорт, импортын үйл ажиллагаа явуулахад шаардлагатай бүх талын мэдээллийг түргэн шуурхай, нэг цэгээс авах боломжийг олгож байгаа юм.

“E-mongolia” цахим хуудасны “Гадаадад байгаа монгол иргэн” гэсэн хэсэгт шинээр хуудас нээж, 40 төрлийн үйлчилгээний холбоос болон тусгай үүргийн нислэг, тусгаарлан ажиглах байрны хуваарь, тусгаарлан ажиглах үйл ажиллагааг зохицуулах түр журам зэрэг мэдээллийг тус цахим хуудсанд 2021 оны 3 дугаар сарын 9-ний өдрөөс эхлэн байршуулав. Дипломат төлөөлөгчийн газруудад цахим нотариатын үйлчилгээ нэвтрүүлэх тухай гэрээг Гадаад харилцааны яам, Монголын Нотариатчдын Танхим хооронд 2021 оны 3 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан. Цахим нотариатын үйлчилгээг нэвтрүүлэх програмын хөгжүүлэлтийг Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагаас санхүүжүүлэхээр болж гэрээг байгуулав.

Дипломат төлөөлөгчийн газруудын нотариатын үйлчилгээг цахимжуулах ажлыг туршилтын журмаар зарим Элчин сайдын яаманд нэвтрүүлэхээр төлөвлөж, хуваарь гарган ажиллаж байна. 5 дугаар 15-ны өдрөөс туршилтын хэлбэрээр Стокхолм, Истанбул, Вена, Берлин, Канберра зэрэг Дипломат төлөөлөгчийн газарт нэвтрүүлэхээр Монголын нотариатчдын танхимтай хамтран ажиллаж байна. Дипломат төлөөлөгчийн газруудын консулын нийт үйлчилгээний 25–30 хувийг нотариатын үйлчилгээ эзэлдэг бөгөөд жилд дунджаар 14,000–15,000 итгэмжлэл гэрчилж байна.



ШУДАРГА ЁС, ЦАХИМ
ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭХ
ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД



//

“Гадаад худалдааны нэгдсэн сан” ашиглалтад орсноор гадаад худалдааны зардлыг бууруулах, гаалийн болон хилийн хяналтын байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, үндэсний хэмжээнд “Цахим нэг цонх”-ны үйлчилгээг нэвтрүүлэхэд чухал ач холбогдолтой ажил болов.

//

ШУДАРГА ЁС, ЦАХИМ
ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭХ
ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

//

Салбарын бүх төрлийн үйлчилгээг нэг системд төвлөрүүлснээр цаг хугацаа, мөнгө хэмнэхээс гадна төрийн үйлчилгээ хэн нэгнээс хамааралгүй болж шат дамжлага, чирэгдэл багасаж, хүнд суртал буурч байна.

//



БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЛБАРЫН ҮЙЛЧИЛГЭЭНҮҮДИЙГ ЦАХИМЖУУЛЛАА

Өмчилсөн газрын лавлагаа, геодезийн тусгай зөвшөөрөл, газрын харилцааны мэргэжлийн байгууллагын эрх олгох үйлчилгээг цахимжуулж, барилгын тусгай зөвшөөрөл, инженер, техникийн ажилтны нэгдсэн мэдээллийн сангийн програмыг хөгжүүлж байна.



www.egazar.gov.mn

Иргэд газар өмчлөлийн лавлагааг тухайн орон нутгийн газрын албанаас өөрийн биеэр очиж авдаг байсан бол одоо цаг хугацаа, орон зайнаас үл хамааран Монгол Улсын иргэн нэг удаа үнэгүй өмчилсөн газрын лавлагааг цахимаар авах боломжтой боллоо.



www.license.gazar.gov.mn

Геодези тусгай зөвшөөрөл, газрын харилцааны мэргэжлийн байгууллагын эрх олгох, сунгах, нөхөн олгох үйлчилгээг веб хандалтад цахим хэлбэрт бүрэн шилжүүлсэн. Тусгай зөвшөөрөл, мэргэжлийн байгууллагын эрх олгохтой холбоотой хүсэлт шийдвэрлэлтийн явцыг иргэн, аж ахуй нэгж цахимаар хянах боломжийг бүрдүүлсэн ба тусгай зөвшөөрөл, мэргэжлийн байгууллагын эрх бүхий аж ахуйн нэгжүүдийн болон салбарын хүний нөөцийн нэгдсэн мэдээллийн санг бий болголоо.



“Барилгын салбарын нэгдсэн мэдээллийн сан”-ийн цахим системийг хөгжүүлэх ажлыг 2020 оны 11 дүгээр сараас эхлэн хөгжүүлж байна. Уг ажлын хүрээнд барилгын салбарын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллага, ИТА, мэргэжилтэй ажилтны бүртгэл, мэдээллийн цахим системийн программ хангамжийг хөгжүүлж, барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйлчилгээг 100 хувь цахим хэлбэрт шилжүүлнэ. Удирдлагын дэд систем, тусгай зөвшөөрлийн эрх хүсэх дэд систем, хүсэлт шийдвэрлэх, хянах дэд систем, портал системийг бүрэн хөгжүүлж, нийт **7,897** аж ахуйн нэгж, байгууллага, **31,820** инженер техникийн ажилтны баталгаажсан мэдээллийг оруулж, хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг эхлүүлээд байна.

Цаашид эдгээр системийг E-Mongolia-ийн нэгдсэн системд холбоно.




ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ БАТЛУУЛЛАА

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлж Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газраас санаачлан боловсруулж, өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал 2021 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж баталлаа. Уг хуулийг 2021 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөж эхлээд байна.



10 ГИШҮҮН
4 ЖИЛ
1 УДАА

ГИШҮҮН 9
ЖИЛ 6
УДАА 1



ХЯНАЛТЫН ШАТНЫ ШҮҮХ-1/НШЧ/

ХЯНАЛТЫН ШАТНЫ ШҮҮХ-1/НШЧ/

ДАВАХ ШАТНЫ ШҮҮХ-2/НШЧ/


ДАВАХ ШАТНЫ ШҮҮХ-2/НШЧ/

АНХАН ШАТНЫ ШҮҮХ-2/НШЧ/

АНХАН ШАТНЫ ШҮҮХ-1/НШЧ/

НЭЭЛТТЭЙ СОНГОН
ШАЛГАРУУЛАЛТ-5 /УИХ/

НЭЭЛТТЭЙ СОНГОН
ШАЛГАРУУЛАЛТ-5 /УИХ/



ШҮҮХИЙН НЭЭЛТТЭЙ,
ИЛ ТОД БАЙДАЛ

ЦАХИМ ШҮҮХ,
ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛЭЭР
ДАМЖУУЛАХ



ШУДАРГА ЁС, ЦАХИМ
ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭХ
ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД



ШҮҮГЧИЙН СОНГОН
ШАЛГАРУУЛАЛТ



ХЭРЭГ НЭХЭМЖЛЭЛИЙГ
ТОХИОЛДЛЫН ЖУРМААР
ХУВИАРЛАХ



ШҮҮГЧИЙН САХИЛГА
ХАРИУЦЛАГА



ХУУЛЬ ЗҮЙ ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ ҮЙЛЧИЛГЭЭГ ЦАХИМЖУУЛЛАА

ШУДАРГА ЁС, ЦАХИМ ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

Монгол Улсын Засгийн газраас цахим үндэстэн болох зорилтын хүрээнд E-Mongolia хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгохын тулд Хүний хувийн мэдээллийн хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хуулийн төслүүдийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн барихад бэлэн болоод байна.


Төрийн үйлчилгээний E-Mongolia системд Хууль зүй, дотоод хэргийн яам, түүний харьяа агентлаг, байгууллагаас 54 үйлчилгээг нэвтрүүлээд байна.



“ Хүний хувийн мэдээллийг хуульд зааснаас бусад тохиолдолд заавал хэрэглэгчийн зөвшөөрөл авч цуглуулах, боловсруулах, ашиглах нөхцөл бүрдэж, эрх нь зөрчигдсөн тохиолдолд гомдол гаргах, эрх хамгаалуулах боломжийг хуулийн төсөлд тусгаж, хүний хувийн мэдээлэл хамгаалах эрх бүхий байгууллагаар Хүний эрхийн Үндэсний Комиссыг тогтоож, бусад төрийн байгууллага мөн тодорхой үүрэг хүлээхээр зохицуулсан.



Нийтийн мэдээллийн системээс олж авах, солилцох боломжтой мэдээллийг хувь хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байх, хуульд цаасан суурьтай байхаар заагаагүй бол мэдээлэл хариуцагчийн баримт бичгийг үйлдэх, дамжуулах, хүлээн авах, хадгалах, хамгаалах болон ашиглахдаа цахим баримт бичигт суурилахаар, мөн цахим баримт бичиг нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэх эрх зүйн үндэслэлийг тодорхой болгох зорилгоор түүний баталгаажилт, хүчинтэй байдлын талаар тусгалаа.



МАРГААНТАЙ БАЙСАН ТӨРИЙН ӨМЧИЙН АСУУДЛЫГ ЦЭГЦЭЛЛЭЭ

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 2 дугаар сарын 10–ны өдрийн 23 дугаар тогтоолоор “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК–ийн 49 хувийн энгийн хувьцааг худалдан авсан гэх талтай харилцан суутган тооцож, 100 хувь төрийн өмчид авахыг Засгийн газарт даалгасан.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 2 дугаар сарын 5–ны өдрийн 41 тоот захирамжаар байгуулагдсан, Сангийн сайд Б.Жавхлангаар ахлуулсан Ажлын хэсэг “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК–ийн 49 хувийн энгийн хувьцааг худалдан авсан гэх талтай харилцан суутган тооцож, төрийн өмчид 100 хувь авахаар Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулан, Засгийн газрын 2021 оны 4 дүгээр сарын 21–ний өдрийн хуралдаанд танилцуулж, 2021 оны 4 дүгээр сарын 29–ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд байна.

ШУДАРГА ЁС, ЦАХИМ ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

“
Улсын Их Хурлын тогтоолын төсөл батлагдсанаар “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК–ийн 49 хувьтай холбоотой маргааныг эцэслэн шийдвэрлэгдэж харилцан суутгал хийх замаар төрийн өмчид 100 хувь авах боломж бүрдэх юм.
”

Эрдэнэт үйлдвэр ХХК, Монголросцветмет ТӨҮГ–ын 49 хувийн холбоотой маргааныг эцэслэн шийдвэрлэж, харилцан суутгал хийх замаар төрийн өмчид 100 хувь авахаар болов.

Ерөнхий сайдын 41 тоот захирамж

Эрдэнэт үйлдвэр ХХК, Монголросцветмет ТӨҮГ–ын 49 хувийг худалдан авсан гэх талтай хэлцэл хийж, суутган тооцох үүрэг бүхий ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан.

Засгийн газрын хуралдаан

УИХ–ын 2017 оны 23 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах санал боловсруулсан Засгийн газрын хуралдаанд танилцуулж, 25 дугаар тэмдэглэл УИХ–д өргөн барихаар тогтов.

Ерөнхий сайдын 41 тоот захирамж

Мэргэжлийн туслалцаа үзүүлэх, санал боловсруулж, танилцуулах үүрэгтэй дэд ажлын хэсэг байгуулав.

УИХ–ын 23 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах УИХ–ын тогтоолын төслийг УИХ даргад өргөн барив.



ИРГЭДИЙН ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ ОРЧИНД АМЬДРАХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЭХ АЖИЛ ХИЙГДЭЖ БАЙНА

ШУДАРГА ЁС, ЦАХИМ
ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭХ
ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД


Нийслэлийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, газар ашиглалтыг сайжруулах, явган хүний зам талбайн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх, авто замын түгжрэлийг бууруулах зорилгоор нийслэлийн Засаг даргын 2021 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн “Газрын зөрчил арилгах арга хэмжээний тухай” А/250 дугаар захирамж, “Хууль журмын хэрэгжилтийг хангах тухай” А/251 дүгээр захирамжийн дагуу авто замын орц гарц, явган хүний зам талбай, нийтийн эзэмшлийн газарт зохих зөвшөөрөлгүйгээр стандартын бус хашаа, хайс барьсан газруудын зөрчлийг арилгаж, газар чөлөөлөх арга хэмжээг холбогдох албан хаагчид халдвар, хамгааллын дэглэмээ сахин ажиллаж байна.

- **Баянгол – 27 байршлын 1,940 метр;**
- **Баянзүрх – 431 байршлын 35,910 метр;**
- **Сүхбаатар – 627 байршлын 43,602 метр;**
- **Хан-Уул – 200 байршлын 18,887 метр;**
- **Чингэлтэй – 445 байршлын 15,414 метр** бүхий газрын зөрчлүүдийг судалгаагаар илрүүлэн, зөрчлийг арилгах ажлыг 2021 оны 4 дүгээр сараас хэрэгжүүлж эхэллээ.

2021 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт 13 байршлын 61 зөрчил бүхий хашаа, шон, хаалт, 2021 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт 10 байршлын 73, 2021 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр 5 байршлын 36 зөрчлийг арилган, авто замын орц гарц, явган хүний зам талбай, нийтийн эзэмшлийн газарт зохих зөвшөөрөлгүйгээр барьсан, стандартын бус 170 гаруй хашаа, шон, хаалтыг чөлөөлж, иргэд зорчиход чөлөөтэй нийтийн эзэмшлийн зам талбай, гарц орцыг нэмэгдүүллээ.

“ Сургууль, цэцэрлэгийн орчинд байдаг, явган хүний зам хааж, авто зам руу түрж орсон хашаа, хайсуудыг татуулж, хүүхэд багачуудыг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлсэн ажлууд үргэлжилж байна.

”





ТӨСВИЙН ҮР АШГИЙГ САЙЖРУУЛЖ, ХЭМНЭЛТИЙН ЗАРЧМААР АЖИЛЛАЖ ЭХЭЛЛЭЭ

Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын эдийн засаг, нийгэмд Учруулсан сөрөг үр дагаврыг арилгах зорилгоор Засгийн газраас 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг баталсан билээ.

Уг тогтоолын дагуу төсвийн мөнгөн хөрөнгийн зохицуулалтын хүрээнд төсвийн орлогын гүйцэтгэлтэй уялдуулж зарлагыг эрэмбэлэн санхүүжүүлэх, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг оновчтой удирдан зохион байгуулах, шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, албан тушаалаас чөлөөлөгдсөн албан хаагчийн орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх, батлагдсан төсөвт зардлын дүнд тодорхой хувийн хэмнэлт гаргах, зарим арга хэмжээг цахим хэлбэрээр зохион байгуулж, холбогдох зардлыг хэмнэх зэрэг багц арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

2022 онд төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлж байгаа төрийн байгууллагын хурал, зөвлөгөөн, сургалт, семинарыг цахимаар зохион байгуулах зэргээр урсгал зардлыг хэмнэх, хөрөнгийн ашиглалтыг сайжруулж, зайлшгүй шаардлагатайгаас бусад худалдан авалтыг зохион байгуулахгүй байх зэрэг арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫГ БҮРЭН ЦАХИМЖУУЛНА	ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУД ХЭМНЭЛТИЙН ЗАРЧМААР АЖИЛЛАНА
<ul style="list-style-type: none"> ✓ Төрийн байгууллагын бичиг хэргийн нэгдсэн системийг нэвтрүүлнэ. ✓ Бүх төрийн байгууллагын цалин хөлсийг цалингийн нэгдсэн системээр олгоно ✓ Төрийн байгууллагын тавилга, тоног төхөөрөмжийн шинэчлэлийг хөрөнгийн бүртгэлийн нэгдсэн цахим сангийн мэдээлэлд үндэслэн бүртгэж, акталж, шинэчилнэ 	<ul style="list-style-type: none"> ✓ Төрийн албан хаагчдын орон тоог нэмэгдүүлэхгүй ✓ Төрийн байгууллагуудыг бүрэн цахимжуулах замаар бичиг хэрэг, томилолт, хурал, зөвлөгөөн, сургалт, семинарын зардлыг эрс бууруулна ✓ Төсвийн хэмнэлтийн талаар авсан зарим арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. ✓ Хөрөнгийн ашиглалтыг сайжруулж, зайлшгүй шаардлагатайгаас бусад худалдан авалтыг зохион байгуулахгүй.

ШУДАРГА ЁС, ЦАХИМ
ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭХ
ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

“

Хэмнэлтийн горимд шилжсэнээр төсвийн урсгал зардал нийт 167 тэрбум төгрөгөөр хэмнэгдэх боломжтой болсон.

”



ШУДАРГА ЁС, ЦАХИМ ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

//

Хуулийн төслүүд батлагдсанаар дараах үр дүнд хүрнэ. Үүнд:

- төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн статус тодорхой болж, компанийн засаглалыг сайжруулах эрх зүйн орчин бүрдэнэ;
- төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглал сайжирч, ашигт ажиллагаа нэмэгдэж, санхүүгийн үр ашиг, компанийн үнэ цэн өсөж, улмаар татварын орлого, төрийн эзэмшлийн өмчийн ногдол ашиг өснө;
- хувийн хэвшил хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, хөрөнгө оруулалт ихээхэн шаардагдах нийтийн эрх ашигт чиглэсэн салбарт төр, орон нутгийн өмчит аж ахуйн нэгж нийгмийн хариуцлага хүлээж үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчин бүрдэнэ.

//

ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИУДЫН ЗАСАГЛАЛЫГ САЙЖРУУЛЖ ЭХЭЛЛЭЭ

Засгийн газраас Төрийн болон орон нутгийн өмчийн бодлого, засаглалыг сайжруулах, төрийн өмчийн хөрөнгө, хуулийн этгээдийн удирдлагын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шинэчлэлийг эхлүүлж, хуулийн төслийг УИХ-д өргөн барилаа.

Тус шинэчлэлийн хүрээнд 1) Төрийн удирдлага, зохицуулалтыг сайжруулж, уялдаа холбоог хангах, 2) Санхүүгийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэх, 3) Зах зээл дэх төрийн өмчийн оролцоог шинэчлэх гэсэн 3 бүлэг арга хэмжээг нэн тэргүүнд авч хэрэгжүүлнэ.

Төрийн удирдлага, зохицуулалтыг сайжруулж, уялдаа холбоог хангах хүрээнд:

- ✓ Асуудал эрхэлсэн яамд, Засгийн Газрын Хэрэг эрхлэх газар төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн бодлогыг чиглүүлж, удирдлагыг хэрэгжүүлж, Төлөөлөн Удирдах зөвлөлийг томилдог болно;
- ✓ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар зөвхөн төрийн өмчийн бүртгэл, тооллого, хяналтын чиг үүргийг хэрэгжүүлдэг болно;
- ✓ Бүх төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд “Тендер”-ийн хуулийг мөрдөж, худалдан авах ажиллагаа зохион байгуулдаг болно;
- ✓ Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага, төрийн төлөөллийн ТУЗ-ийн гишүүд Компанийн тухай хуульд заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийн заалтыг хатуу мөрдөхийг даалгана.

Санхүүгийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэх хүрээнд:

- ✓ Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлж, гүйцэтгэх удирдлагыг 1–2 жилийн хугацаанд санхүүгийн үзүүлэлтийг сайжруулах нөхцөлтэй гэрээгээр томилж, гэрээг сунгадаг болно;
- ✓ Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг чанд сахиулна.
- ✓ Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн орон тооны зохистой түвшнийг тогтоож удирдлагын давхардлыг арилгаж, дарга нарын тоог цөөлнө.

Зах зээл дэх төрийн өмчийн оролцоог шинэчлэх хүрээнд:

- ✓ Төрөөс үнийн зохицуулалт хийдэг болон стратегийн ач холбогдолтой салбарт үйл ажиллагаа эрхэлдэг төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийг зарлаж төр 100 хувь эзэмшинэ;
- ✓ Санхүүгийн хувьд цаашид ажиллах боломжгүй, хувийн хэвшлийн хийх боломжтой аж ахуйн шинжтэй үйл ажиллагаа эрхэлдэг төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийг нэгтгэх, цаашлаад татан буулгана;
- ✓ Төрийн оролцоо байх шаардлагатай төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 34 хүртэлх хувийг Хөрөнгийн биржээр дамжуулан нээлттэй арилжаалах эсхүл нэмэлт хувьцаа гаргах замаар санхүүжилтийг босгож жижиг хувьцаа эзэмшигчдийг оролцоог хангана.

ХӨРШ БОЛОН БУСАД УЛС ОРНУУДАЙ ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЛЭЭ

ОХУ, БНХАУ–тай иж бүрэн стратегийн түншлэлийн түвшинд хамтран ажиллаж байна. Энэхүү хамтын ажиллагааг цар тахлын үед ч хэвийн үргэлжлүүлэх, томоохон төсөл хэрэгжүүлэх, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэхэд бүхий л хүрээнд идэвхтэй ажиллаж байна. Тухайлбал, Монгол, Оросын хооронд дипломат харилцаа тогтоосны 100 жилийн ойг хамтран тэмдэглэх 92 заалт бүхий арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Монгол, Оросын ЗГХК–ын үндэсний дарга нарын цахим уулзалтыг зохион байгуулж, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх олон чиглэлийг тусгасан Протокол байгуулав. ОХУ–тай бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны дунд хугацааны хөтөлбөрийг эцэслэн баталж, хэрэгжүүлж эхлэв.

Ковид 19–ийн эсрэг вакциныг тусламжаар авах, худалдан авах яриа хэлэлцээг хоёр хөрш болон гуравдагч хөршийн томоохон улсуудтай хийж, манай улсад ашиглаж буй вакцины дийлэнх хувийг аваад байна.

“Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал”–ыг ашиглалтад оруулах (Япон Улс), “Газрын тос боловсруулах үйлдвэр” барьж байгуулах (Энэтхэг Улс), “Солонго 1, 2 орон сууцны хороолол”, “Баянголын аманд түрээсийн орон сууцны хороолол” барих (Бүгд Найрамдах Солонгос Улс) зэрэг томоохон төслүүдийн хэрэгжилтийг урашлуулах чиглэлээр үргэлжлүүлэн ажиллаж байна.

Монгол Улс, Европын Холбооны Бодлогын анхдугаар яриа хэлэлцээг 2021 оны 3 дугаар сарын 10–ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулав. Энэхүү яриа хэлэлцээ нь Монгол Улс, Европын Холбоо хооронд байгуулсан Түншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээр хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш анх удаа болж буйгаар онцлог бөгөөд Монгол Улс, Европын Холбооны хамтын ажиллагааны хамтарсан хорооны дэргэд цаашид жил бүр хуралдана.

Турк Улстай байгуулсан Нийгмийн хамгааллын тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийг хоёр талд соёрхон баталснаа харилцан мэдэгдсэнээр энэхүү хэлэлцээр 2021 оны 3 дугаар сарын 1–ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхлэв.

АНУ–ын Конгрессын Сенатын танхим “Монгол–Америкийн Стратегийн түншлэлийг бэхжүүлэх тухай” тогтоолыг 2021 оны 4 дүгээр сарын 15–ны өдөр батлав.

“Гуравдагч хөршийн худалдааг дэмжих тухай хууль” (Mongolia Third Neighbour Trade Act)–ийн төслийг 2021 оны 4 дүгээр сарын 22–ны өдөр АНУ–ын Конгрессын Төлөөлөгчдийн танхимд дахин өргөн барилаа.



ШУДАРГА ЁС, ЦАХИМ ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД



ШУДАРГА ЁС, ЦАХИМ
ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭХ
ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

МОНГОЛ ОРНЫГ ДЭЛХИЙ НИЙТЭД СУРТАЛЧЛАХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Гадаад харилцааны яам, Соёлын яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны гурвалсан ажлын уулзалтыг 2021 оны 3 дугаар сарын 6-нд зохион байгуулж, гадаад сурталчилгааны контент бэлтгэх, хилийн чанадад суугаа дипломат, төлөөлөгчийн газруудаар дамжуулан түгээх ажлыг зохион байгуулахаар тохирч гадаад сурталчилгааны нэгдсэн төлөвлөгөөг боловсруулав.

Соёлын сайд Ч.Номин Тайландын Хаант Улсын Соёлын сайд Иттипол Кунплемтэй 2021 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр цахим уулзалт хийж, соёл урлагийн арга хэмжээ, наадам зохион байгуулах, кино болон урлагийн фестивальд уран бүтээлчдийн оролцоог хангах, харилцан үзэсгэлэн зохион байгуулах, түүхийн дурсгалт зүйлсийг хадгалж хамгаалах чиглэлээр хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар санал солилцов.

Олон Нийтийн цахим сүлжээгээр дамжуулан Монгол орноо сурталчлах үүднээс “Welcome to Mongolia”, “Open Mongolia” фэйсбүүк хуудсыг нээн ажиллуулж байна. Мөн инстаграм, фэйсбүүкт олон дагагчтай, гадаадад ажиллаж, амьдардаг Монголчуудтай хамтран ажиллаж, улс орноо сурталчилсан контент гаргахаар ажиллаж байна.



ЦЭРГИЙН ЗОРИУЛАЛТТАЙ МАШИН ТЕХНИКИЙГ ҮЙЛДВЭРЛЭЖ ЭХЭЛЛЭЭ

Цэргийн шинжлэх ухаан, батлан хамгаалах үйлдвэрлэлийг хөгжүүлэх, цэргийн зориулалттай зарим төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх зорилтын хүрээнд Цэргийн шинжлэх ухааны судалгаа, шинжилгээний ажлыг эрчимжүүлж, Зэвсэгт хүчний анги, байгууллагыг түшиглэн туршилт-үйлдвэрлэлийн төвүүдийг байгуулж, үйл ажиллагааг нь эхлүүлснээр батлан хамгаалах аж үйлдвэрийн суурийг тавиад байна.

Өнөөгийн байдлаар Туршилт-үйлдвэрлэлийн төвүүдийг түшиглэн Тусгай зориулалтын цэргийн авто техник, нисгэгчгүй нисэх төхөөрөмж, радио электрон хэрэгслийн эхний загваруудыг бүтээгээд байна.

1. Бүлгийн байлдааны машиныг бүтээх төслөөр 2 болон 3 тэнхлэгтэй автомашиныг 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлсэн ба үйлдвэрлэлийн явц 54.3 хувьтай байна;
2. Тагнуул-дайралтын машин /Багги/ бүтээх төслөөр Багги автомашин үйлдвэрлэх ажлыг 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлсэн ба үйлдвэрлэлийн явц 33.3 хувьтай байна;
3. Хөнгөн хуягласан байлдааны машин бүтээх төслөөр туршилтын загварыг бүтээх ажил 90 хувийн гүйцэтгэлтэй байна. 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөс хөнгөн хуягласан байлдааны машин үйлдвэрлэх ажил эхэлсэн, үйлдвэрлэлийн ажлын явц 20.3 хувьтай байна.

Нисгэгчгүй нисэх системийн судалгаа, туршилтын төвийг шаардлагатай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр ханган, судалгаа-туршилт-зохион бүтээлтийн үйл ажиллагааг нь эхлүүлж, орон зайн тандалт, агаарын тагнуулын зориулалт бүхий бага оврын “Ёл-1” загварыг бүтээгээд байна.

Дунд оврын “Ёл-2” загварыг бүтээх ажлыг 75 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж байна. “Ёл-1”, “Ёл-2” нисгэгчгүй нисэх төхөөрөмжийг зохион бүтээх судалгаа, туршилтын үр дүнд үндэслэн босоо хөөрөлтийн технологи бүхий нисэх зурвас шаардахгүй хөөрөх, буух боломжтой “Хяналт-1” нисгэгчгүй нисэх төхөөрөмжийг бүтээх төслийг хэрэгжүүлж байна.



ШУДАРГА ЁС, ЦАХИМ
ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭХ
ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД



“

Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлснээр:

- 1) Батлан хамгаалах аж үйлдвэрийн суурь тавигдах;
- 2) Цэргийн шинжлэх ухааны судалгаа, шинжилгээний ажлыг хөгжүүлэх;
- 3) Зэвсэгт хүчний тусгай хүчний анги, салбаруудын гал, маневрын боломж нэмэгдэх;
- 4) Гадны худалдан авалтыг багасгаж, эх орондоо нэмүү өртөг шингээсэн техник, технологийг хөгжүүлэх нөхцөл бүрдэх.

”



КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТӨВИЙГ БАЙГУУЛЛАА

ШУДАРГА ЁС, ЦАХИМ
ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭХ
ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

Зэвсэгт хүчний тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Зэвсэгт хүчний бүтцэд Кибер аюулгүй байдлын цэрэг байгуулж, кибер халдлагатай тэмцэх чадавхыг бэхжүүлэх хүрээнд “Кибер аюулгүй байдлын төв”-ийг байгууллаа.

НАТО-ийн “Аюулгүй байдал, энхийн төлөө шинжлэх ухаан” хөтөлбөрийн хүрээнд 2014 оноос хэрэгжүүлж эхэлсэн Монгол Улсын кибер орон зайг хамгаалахад дэмжлэг үзүүлэх зорилготой Зэвсэгт хүчний Кибер аюулгүй байдлын төвийн чадавх, мэргэжлийн хүний нөөц болон техник хэрэгслийн чадамжийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдол бүхий мэдээллийн технологийг хамгаалах компьютерийн халдлагад хариу үзүүлэх бүлэг байгуулах төслийг амжилттай хэрэгжүүлж “Кибер аюулгүй байдлын төв”-ийг нээлээ.



“ Тус төвийг байгуулснаар Зэвсэгт хүчин кибер халдлагыг илрүүлэх, таслан зогсоох, хариу үйлдэл үзүүлэх, кибер орон зайд тавигдсан үүргийг гүйцэтгэх, гадны халдлагаас хамгаалах боломж, нөхцөл бүрдэж, кибер аюулгүй байдлын зэрэглэл нэмэгдэх ач холбогдолтой юм.

”

ГАМШГААС ХАМГААЛАХ, АВРАХ АЖИЛЛАГААНЫ ХҮЧИН ЧАДЛЫГ НЭМЭГДҮҮЛЛЭЭ

Гамшгаас хамгаалах, ард иргэдэд онц байдлын үед түргэн шуурхай тусламж үзүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх 14 төрлийн нийт 71 нэгж гал түймэр унтраах тусгай зориулалтын автомашин (гал түймэр унтраах үндсэн албаны 40, тусгай албаны 12, туслах албаны 2, бусад төрлийн 17), ЕС-145 маркийн 2 нисдэг тэргийг Онцгой байдлын байгууллага хүлээн авч, Онцгой байдлын байгууллагын анги, салбаруудад хуваарилан, холбогдох ажилтнуудад сургалт зохион байгууллаа.

Онцгой байдлын байгууллагын гал түймэр унтраах тусгай зориулалтын автомашины хангалт 14.1 хувиар нэмэгдлээ.

Засгийн газар агаараас эрэн хайх, аврах 111 дүгээр ангийг байгуулах ажлыг эрчимжүүлж, тус ангийн бүтэц, орон тоог баталлаа. Нисэгч, инженер, техникийн ажилтнуудыг бэлтгэх Франц багштай сургалтад 28 хүнийг хамруулж байна.

Монгол оронд тохиолдож байгаа байгалийн болон хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй ган, зуд, газар хөдлөлт, хими, биологи, цацрагийн аюул, үйлдвэрлэлийн болон зам тээврийн осол, ой, хээрийн болон өндөр барилгад гарсан гал түймэр, хүчтэй цасан болон шороон шуурга зэрэг онцгой байдлын үед эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах ажиллагааг явуулах, эмнэлэг, хүмүүнлэгийн тусламжийг цаг алдалгүй хүргэх нисэх нэгж Онцгой байдлын байгууллагад байгуулагдаж байна.

2020 онд улсын хэмжээнд 4,894 аюулт үзэгдэл, ослын дуудлагаар онцгой байдлын алба хаагчид 2,234 хүний амь нас, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн 114.5 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг авран хамгаалсан байна.



ЦАР ТАХЛЫГ БОГИНО ХУГАЦААНД ДАВАН ТУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

“ Тусгай зориулалтын автомашин, техник тоног төхөөрөмжийг нэмэгдүүлснээр тайлант хугацааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад объектын гал түймрийн дуудлага 28 хувь, ой хээрийн гал түймрийн тохиолдол 17.2 хувь өссөн хэдий ч учруулсан хохирол 86.5 хувь буурлаа. ”



